



**МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ
БАЯЛГИЙН САНГИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛҮҮДЭД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС
ӨГӨХ ДҮГНЭЛТ**

УЛААНБААТАР ХОТ
2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр

АГУУЛГА

1. Төсвийн бодлогын талаар	3
2. Нийт орлого ба тусламжийн талаар.....	4
3. Нийт зарлага ба цэвэр зээлийн талаар	7
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар.....	12
5. Засгийн газрын нийт өр, төлбөрийн талаар	15
6. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн талаар.....	22
7. Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн талаар	26
8. Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн талаар	29
9. Улсын хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх.....	31
10. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх	33
11. Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх	34
12. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмж	36
 Хавсралт 1. Төсвийн урсгал зардлын бүрэлдэхүүний инфляцад үзүүлэх нөлөө	38
Хавсралт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой асуудлаар УИХ-аас гаргасан тогтоолууд	40
Хавсралт 3. Цалин, тэтгэврийн зардлын дунд хугацааны төлөв.....	41

**МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН САНГИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН
САНГИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДЭД ТӨСВИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ**

Монгол Улсын 2027 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2027 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 2026 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Эдгээр хуулийн төслүүдэд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8.4.8 дахь заалт, Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 23.1 дэх заалтын дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дүгнэлт гаргалаа.

ТТБЗ-ийн зүгээс өргөн мэдүүлсэн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн (ТТБТХ) 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 7.3-т заасан “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэснийг баримталсан эсэх, мөн Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 6.2.1, 6.2.2, 6.3.3, 6.4.1, 27 дугаар зүйл, 32.2-т заасны дагуу боловсруулагдсан эсэхэд анхаарсан болно.

1. ТӨСВИЙН БОДЛОГЫН ТАЛААР

1.1. Төсвийн бодлого, эрх зүйн орчны өөрчлөлт нь төсвийг тэлэх шалтгаан болж байна. УИХ-д 2026 оны 08 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн тухай хуулийн төсөлд “... Мөн эдийн засгийн эрх чөлөө, татвар, нийгмийн даатгал, ашигт малтмалын салбарт хэрэгжүүлэх хууль эрх зүйн шинэчлэлтэй төсвийн бодлого, арга хэмжээг уялдуулсан болно. Ирэх жилийн төсвийн бодлогыг иргэдийн бодит орлого, нийгмийн баталгааг хамгаалах, төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, төвлөрсөн зарим чиг үүргийг төсвийн хамт орон нутагт ишлжүүлж, төвлөрлийг сааруулахад чиглүүлнэ. Үүний зэрэгцээ боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, эрчим хүч, зам, логистикийн хүртээмжийг сайжруулж, төрийн бүтээмж, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал, хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэн, ипотекийн зээлийн хүртээмжийг өргөжүүлнэ” (МУЗГ, 2026) гэж заасан нь 2027 оны төсвийн бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж байна гэж үзэж байна. Энд дурдагдаж буй татвар, нийгмийн даатгалын шинэчлэл болон төрийн албан хаагчдын цалин хөлсний бодлого нь 2027 онд зарлагыг 36,493.4-43,586.0 тэрбум төгрөгт хүргэж 7,092.6 тэрбум төгрөгөөр өсгөх, ДНБ-д эзлэх хувийг 31.9-37.8 хувьд хүргэж 5.9 хувиар, төсвийн алдагдлыг -1,713.4 тэрбум төгрөгөөс -2,306.0 тэрбум төгрөг болгож тус тус нэмэгдүүлэх нэг үндсэн шалтгаан болж байна.

1.2. ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувь хэмжээг огцом өсгөж байгаа нь Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нийцэхгүйгээс гадна дунд орлоготой орнуудын түвшнээс давж, өндөр орлоготой орнуудын түвшинд хүрсэн байна. 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр УИХ-аас “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” тогтоол батлахдаа Засгийн газрын өр, төсвийн алдагдал болон төсвийн урсгал зардлын ДНБ-д эзлэх хувийг үе шаттайгаар бууруулахаар тусгасан.

Хүснэгт 1. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зарим шалгуур үзүүлэлт

Үзүүлэлт (ДНБ-д эзлэх хувь)	2024 (суурь он)	2026	2027	2028	2029	2030
Төсвийн нийт зарлага	38.3	32.2	30.0	28.6	28.0	28.0
Төсвийн урсгал зардал	27.5	24.0	23.0	22.0	22.0	22.0
Засгийн газрын нийт өр	60.0	50.0	45.0	45.0	45.0	45.0

Эх сурвалж: УИХ-ын 2025 оны 109-р тогтоолын 3-р хавсралт

Өргөн мэдүүлсэн төсөлд ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлагыг 2027 онд 37.8 хувь, Засгийн газрын өрийн нийт хэмжээг 50 хувьд тус тус хүргэхээр тусгасан нь таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтүүдээс харгалзан 7.8 болон 5.0 нэгж хувиар хэтэрсэн байна. Улмаар төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь 2026 оны байдлаар өндөр орлоготой орнуудад дунджаар 41.1 хувь, дунд орлоготой орнуудад 32.2 хувь, Монгол Улсын тухайд 37.8 хувь байгаа нь орлогын бүлгийн дунджаас хол давсан үзүүлэлт болохоор байна.

1.3. Төсвийн зарлагыг татварын орлогоор санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал болсноос төсвийн орлогын бүтцэд өөрчлөлт хийх шаардлага бий болж байна. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2027 онд 9,350.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэх бөгөөд үүний 3,939.3 тэрбум төгрөг буюу 42 хувийг татварын орлого, 5,410.7 тэрбум төгрөг буюу 58 хувийг татварын бус орлого бүрдүүлэхээр байна. Төрийн өмчит компанийн ногдол ашиг, түүнчлэн Оюутолгой ХХК-ийн ногдол ашиг төсвийн орлогын өсөлтийн гол бүрэлдэхүүн болж байгаа бөгөөд эдгээр нь тогтвортой байх эсэхээс цаашид төсвийн орлогын эрсдэл хамаарахаар байна. Сүүлийн хоёр жилд татварын орлого төлөвлөсөн дүнгээс бага байх хандлагатай байгаа нь татварын орлогыг эдийн засгийн бодит нөхцөл, үйл ажиллагаатай уялдуулан тооцох шаардлагатайг харуулж байгаа төдийгүй татварын орлого төсвийн зарлагыг санхүүжүүлэх боломж хязгаарлагдсан нь орлогын бодлогод өөрчлөлт оруулах нөхцөл, шаардлага болж байна.


1.4. Эдийн засгийн бүтцийн гажуудалтай нөхцөлд төсвийн зарлагыг тэлэх нь дунд хугацаанд төсвийн эрсдэлийг нэмэгдүүлэхээр байна. Өнөөгийн эдийн засгийн тэлэлт уул уурхай, тээврийн салбарын идэвхжилээр тэтгэгдэж байгаа хэдий ч нөгөө талдаа худалдаа, үйлчилгээний салбар уналттай буюу сөрөг утгатай гарсан. Барилгын салбарын болон хэрэглээний өсөлт нь төрийн бүтээн байгуулалт, төрийн хэрэглээний үр дүнд бий болсон нь төрийн оролцоо эдийн засгийн өсөлтөд томоохон нөлөөтэй болж байгааг илэрхийлнэ. Үүнээс гадна ажиллах хүчний оролцоо, өрхийн бодит орлого буурч байгаа зэрэг сөрөг үзэгдлүүд эдийн засгийн өсөлт хүртээмжтэй бус бөгөөд бүтцийн гажуудалтай байгааг харуулна. Татварын орлогын бууралт ч үүний нэг илрэл мөн. Ийм нөхцөлд төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлэх нь дунд хугацаанд төсвийн эрсдэлийг нэмэгдүүлэх нөлөөтэй.

2. НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ТАЛААР

2.1. Төсвийн орлогын бүтцэд татварын бус орлогын эзлэх хувь нэмэгдэж буй нь эерэг өөрчлөлт боловч уул уурхайн салбараас хамаарах хамаарлыг нэмэгдүүлж байгаа эрсдэлтэй алхам юм. Татварын бус орлогыг 2027 онд энэ оноос 5,410.7 тэрбум төгрөгөөр өсгөж 8,275.1 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөсөн нь түүхэн өндөр үзүүлэлт болж байна. Үүнээс 3,544.8 тэрбум төгрөг нь төрийн өмчит хуулийн этгээдүүдээс, 162 тэрбум төгрөг нь орон нутгийн өмчит хуулийн этгээдээс, 2.0 их наяд төгрөг нь Оюутолгой төслөөс авах

ногдол ашиг байна. Төсвийн орлогод татварын бус орлого нэмэгдэж байгаа нь олон улсын жишгийн хувьд зөв хандлага мөн ч тухайн орлогын уул уурхайн салбараас хамааралтай байдал нь төсвийн орлого бүрдүүлэлтэд цаашид сөргөөр нөлөөлөх магадлал өндөр юм.

Зураг 1. Нэгдсэн төсвийн 2020-2027 оны нийтлэг татварын бус орлогын бүрэлдэхүүн, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн танилцуулга

2.2. Төрийн өмчийн компанийн ногдол ашгийн тодорхой хэсгийг улсын төсөвт төвлөрүүлж байгаа нь төрийн өмчийн хяналт, нэгдмэл бодлогын хэрэгжилтэд эерэг нөлөөтэй. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглалын тухай хууль болон Монгол Улсын 2026 оны төсвийн тодотголтой хамт өргөн мэдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит хуулийн этгээдээс улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэнэ гэж тооцжээ. Төрийн өмчийн компаниудын засаглал, үр ашгийг сайжруулах, ашигтай ажиллах нөхцөл бүрдүүлэх, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх нь төсвийн нэгдмэл байдлыг хангахад эерэг нөлөөтэй гэж үзэж байна.

2.3. Оюутолгой төслөөс ногдол ашиг авах болсон нь төсвийн орлогыг өсгөж байна. Төсвийн төсөлд нийтлэг татварын бус орлогоор 2027 онд 7,853.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсний 2.0 их наяд төгрөг нь Оюутолгой төслөөс авах ногдол ашиг байхаар байна. Төсөлд дурдсанаар “... Оюутолгой төслөөс Монгол Улсын төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос 2,000.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт, ... 1,000.0 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлэхээр ...” тооцжээ. Ийнхүү Оюутолгой төслөөс төвлөрүүлэх эдгээр орлогоор Хуримтлалын сан, төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээр төсвийн төсөлд тусгасан байна.

2.4. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны нийт орлого ба тусламжийн дүнгийн бодит өсөлт нь тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнгийн өсөлтөөс 2.7 нэгж хувиар доогуур байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021-2027 оны нийт орлого ба тусламж, тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн бодит өсөлтийг харьцуулахад 2022, 2023, 2027 онд тэнцвэржүүлсэн орлогын өсөлт нь нийт орлого ба тусламжийн дүнгээс илүү байсан бол 2021, 2024, 2025 онд нийт орлого ба тусламж нь тэнцвэржүүлсэн орлогоос өндөр хувьтай өсжээ.


Зураг 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021-2027 оны нийт орлого ба тусламж болон тэнцвэржүүлсэн орлогын бодит өсөлтийн харьцуулалт, хувиар



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн мэдээлэлд үндэслэн ТТБЗ-өөс хийсэн тооцоолол

2.5. Татварын хуулийн өөрчлөлтийн эдийн засгийн идэвхжил, татварын суурийн өргөжилтөд үзүүлэх нөлөөлөл тодорхой бус байна. Татварын орлогыг 2027 онд 2026 оны тодотгол хийхээр өргөн мэдүүлсэн орлогын дүнгээс 3,939.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 33,004.9 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөжээ. Үүний 30.7 хувийг орлогын албан татвар, 24 хувийг нийгмийн даатгалын шимтгэл, 24.6 хувийг нэмэгдсэн өртгийн албан татварын орлого, 6.1 хувийг гаалийн албан татвар, 4.1 хувийг онцгой албан татвар, үлдсэн 10.5 хувийг хөрөнгийн болон бусад татварын орлого эзэлж байна.

Зураг 3. Нэгдсэн төсвийн 2020-2027 оны татварын орлогын бүтэц, хувиар



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн танилцуулга

Татварын орлогыг бүтцээр нь задалж үзвэл орлогын албан татвар 2020-2023 оны дундаж утга болох 26.7 хувиас 2024 онд эрс нэмэгдэж, 32.7 хувьд хүрсэн бол 2025-2026 онд 30.7-31.5 хувьд тогтвортой хадгалагдаж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2024 онд татварын орлогын 17.3 хувийг эзэлж байсан бол 2027 онд 24.0 хувь болж 6.7 хувиар нэмэгдэхээр байна. Засгийн газар 2027 оноос эхлэн сарын 792 мянган төгрөг хүртэлх цалинг ХХОАТ-аас чөлөөлөх, ААНОАТ-ын шатлалыг өөрчлөх, жижиг болон бичил ААН-ийн 1 хувийн татварын босгыг 1.5-аас 2.5 тэрбум төгрөг болгох, зарим ногоон технологийн импортын татварыг тэглэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Иймээс


Засгийн газар ХХОАТ, ААНОАТ-д оруулсан өөрчлөлтөөс үүдэн татварын ачаалал буурснаар эдийн засгийн идэвхжил, татварын суурь хэр хэмжээгээр өргөжих талаар тооцоолол хийж, үр дүнг нь УИХ-д тайлагнадаг болох шаардлагатай.

2.6. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал, буцаан олголт буюу татварын зарлага нэмэгдэж байгаа ч түүний зорилго, үр дүнд шинжилгээ хийж байх шаардлага тулгарч байна. Төсвийн төсөлд 2027 онд татварын зарлага 1,783.1 тэрбум төгрөг буюу нийт татварын орлогын 5.5 хувь болохоор байна. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг татварын төрлөөр авч үзвэл ААНОАТ 1,051.6 тэрбум төгрөг, НӨАТ 436.8 тэрбум төгрөг, гаалийн татвар 161.4 тэрбум төгрөг, ХХОАТ 133.3 тэрбум төгрөг байна. Ийнхүү татварын зарлагын дүн нэмэгдсээр байгаа нь цаашид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт бүр ямар зорилгоор хэрэгжиж, хэмжигдэхүйц ямар үр дүнг бий болгож байна вэ, зорилтот бүлэгтээ хүрсэн үү, төсөвт орлого алдах өртөг нь эдийн засгийн үр өгөөжөөсөө бага байна уу гэдгийг шинжлэн тогтоох шаардлагыг үүсгэж байна.

3. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ТАЛААР

3.1. Төсвийн зарлагыг огцом нэмэгдүүлж байгаа нь төрийн оролцоог бууруулах бодлогын чиглэлд нийцэхгүй байна. ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлагын хэмжээ 2020-2024 оны дунджаар 35.3 хувь байсан бол 2025 онд 34.8 хувь болж буурсан бөгөөд 2026 онд 33.2 хувь болох хүлээлттэй байгаа боловч 2027 онд 37.8 хувь болж, 2026 оны тодотгол хийхээр өргөн мэдүүлсэн дүнгээс 4.6 хувиар огцом өсөхөөр төлөвлөжээ.

Зураг 4. Нэгдсэн төсвийн 2020-2027 оны нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн танилцуулга

Энэ өөрчлөлт нь эдийн засаг дахь төрийн оролцоог эдийн засгийн өсөлтийг дэмжих оновчтой түвшнээс 10.8 нэгж хувиар өндөр болгож, төрийн оролцоог бууруулахаар сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн бодлогоос татгалзаж буйг харуулж байна.

3.2. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага өмнөх жилүүдийн тогтворжих хандлагаас эргээд өндөр өсөлтийн төлөвт шилжсэн нь голлон урсгал зардлын өсөлтийн шалтгаантай байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, цэвэр зээлийн дүн 2020-2024 онд дунджаар 21.5 хувиар өссөн бол 2025 онд 2.4 хувь, 2026 оны төсвийн тодотголын саналаар 8.4 хувь хүртэл буурч тогтворжиж байсан. Гэвч 2027 оны нэгдсэн төсвийн нийт зарлага болон эргэж төлөгдөх цэвэр зээлийг 43,586.0 тэрбум төгрөгөөр төлөвлөж, 2026 оны төсвийн тодотгохоор өргөн мэдүүлсэн дүнгээс 9,608.0 тэрбум төгрөгөөр буюу 28.3 хувиар огцом өсгөхөөр тооцоолжээ. Үүний дотор урсгал зардал 33,583.2 тэрбум төгрөг болж 7,529.2 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 10,333.3 тэрбум төгрөг болж 1,918.9 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр байна.

Хүснэгт 2. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2025	2026 бат.	2026 тод.	2027 төс.	Зөрүү 27/26 тод.
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,331.0	32,980.0	33,978.0	43,586.0	9,608.0
1.Урсгал зарлага	24,237.8	24,901.9	26,054.0	33,583.2	7,529.2
1.1 Цалин, хөлс	6,229.1	6,990.6	7,687.8	9,190.3	1,502.5
1.2 Бараа, үйлчилгээний бусад зардал	3,895.7	2,948.3	2,923.1	3,719.8	796.7
1.3 Зээлийн үйлчилгээний төлбөр	1,548.2	1,299.2	1,299.2	1,572.7	273.5
1.4 Татаас	799.6	728.2	1,057.8	1,306.8	249.0
1.5 Урсгал шилжүүлэг	11,765.2	12,935.5	13,086.1	17,793.6	4,707.5
1.5.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	2,632.0	2,868.6	2,910.6	3,489.4	578.8
1.5.2 Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	5,884.9	6,583.6	6,779.8	9,070.4	2,290.6
1.5.3 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,420.3	2,641.7	2,592.0	2,737.1	145.0
1.5.4 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	415.7	540.6	509.0	1,670.4	1,161.4
1.5.6 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	231.7	163.4	157.2	484.9	327.7
1.5.7 Хөдөө тогтвортой ажилласны дэмжлэг	146.8	122.0	121.3	323.6	202.3
1.5.8 Бусад урсгал шилжүүлэг	33.8	15.6	16.1	17.8	1.7
2.Хөрөнгийн зардал	7,074.0	8,568.5	8,414.4	10,333.3	1,918.9
2.1 Барилга байгууламж	5,158.1	3,649.0	3,447.1	6,563.9	3,116.8
2.2 Их засвар	381.2	172.4	165.0	309.5	144.5
2.3 Тоног төхөөрөмж	-	664.5	591.4	415.9	(175.6)
2.4 ТЭЗҮ-Зураг төсөв	-	28.4	17.6	35.5	17.9
2.5 Цахим систем	-	13.1	3.5	8.8	5.3
2.6 Бусад хөрөнгө	1,534.7	4,006.6	4,155.2	2,983.1	(1,172.1)
2.7 Стратегийн нөөц хөрөнгө	-	34.6	34.6	16.6	(18.0)
3. Эргэж төлөгдөх цэвэр зээл	(19.2)	(490.4)	(490.4)	(330.5)	159.9

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн танилцуулга

Эндээс нийт зарлагын өсөлтийн 78.4 хувийг урсгал зардал, 21.6 хувийг хөрөнгийн зардлын өсөлт бүрдүүлж байгаа нь харагдана. Энэ нь төсвийн нийт зарлага өмнөх жилүүдийн тогтворжих хандлагаас эргэн өндөр өсөлтийн төлөвт шилжиж, зарлагын өсөлтийн гол хэсгийг урсгал шинжтэй зардал бүрдүүлж буйг илтгэнэ.

3.3. Зарлагын өсөлтийг төрийн өмчийн компанийн болон Оюутолгой төслийн ногдол ашгаар санхүүжүүлж байгаа нь төсвийн гүйцэтгэлд эрсдэл учруулж болзошгүй байна.


Эдгээр нь голчлон уул уурхайн салбарын компани байгаа нь бодлогын сонголтын хувьд анхаарах асуудал төдийгүй Оюутолгой төслийн ногдол ашиг баталгаатай эсэхээс шалтгаалан төсвийн бодлого, хэрэгжилтийн эрсдэл цаашид нэмэгдэх магадлалтайг бодлого, төлөвлөлтийн хүрээнд анхаарах шаардлагатай. Бидэнд байгаа мэдээллээр улс төр, бизнесийн хүрээнд уг асуудал маш идэвхтэй яригдаж байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газар, “Рио Тинто” компани Хувь нийлүүлэгчдийн гэрээнд томоохон өөрчлөлт оруулж,

2027 оноос анх удаа ногдол ашиг хуваарилах тал дээр хамтарч ажиллахаа албан ёсоор мэдэгдсэн.

3.4. Урсгал зардлын нийт дүнд байнга давтагдан гардаг зардлын эзлэх хувь нэмэгдэж байгаа нь дунд хугацаанд төсвийн уян хатан байдал алдагдах нөхцөл бүрдүүлж байна.

Урсгал зардал өмнөх оноос 7,529.2 тэрбум төгрөгөөр өсөж буйг гол бүлгээр нь задалж үзвэл урсгал шилжүүлэг хамгийн өндөр 4,707.5 тэрбум төгрөг (62.5 хувь), цалин хөлс 1,502.5 тэрбум төгрөг (20.0 хувь), бараа үйлчилгээний зардал 796.7 тэрбум төгрөгөөр (10.6 хувь), зээлийн үйлчилгээний төлбөр 273.5 тэрбум төгрөг (3.6 хувь), татаас 249.0 тэрбум төгрөг (3.3 хувь) тус тус нэмэгдэхээр байна.


Зураг 5. Урсгал зардлын дүн, тэрбум төгрөг, өсөлтийн хувиар



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн танилцуулга

Урсгал шилжүүлгийн өсөлтийг задалж харвал нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж 2,290.6 тэрбум төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 1,161.4 тэрбум төгрөг, Засгийн газрын урсгал шилжүүлэг 578.8 тэрбум төгрөг, тэтгэвэрт гарахад төрөөс олгох нэг удаагийн тэтгэмж 327.7 тэрбум төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох дэмжлэг 202.3 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж 145.0 тэрбум төгрөгөөр өсөж байна.

Зураг 6. Урсгал зардлын бүтэц, хувиар



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн танилцуулга

Урсгал зардлын бүтцэд татаас, урсгал шилжүүлгийн зардал 2022 оны 68 хувиас алгуур буурч, 2025 онд 52 хувьд хүрсэн. Гэвч урсгал шилжүүлгийн зардал 2026-2027 онд эргэн тэлэх хандлагатай болж, 2027 онд 57 хувьд хүрэхээр төлөвлөгдсөн байна.

Нийт зарлагын өсөлтийн 78.4 хувь нь урсгал зардлын өсөлтөөс бүрдэж байгаагийн дотор урсгал шилжүүлэг дангаараа нийт зарлагын өсөлтийн 49.0 хувийг эзэлж байгаа нь 2027 оны зарлагын өсөлт хөрөнгө оруулалтаас илүүтэй урсгал шинжтэй зардалд төвлөрч байгааг харуулж байна.

3.5. Төрөөс иргэдэд олгох тэтгэвэр тэтгэмж, урамшууллын зардал огцом нэмэгдэж байна. Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 2023-2026 оны хооронд жилд дунджаар 24 орчим хувиар нэмэгдсэн бол 2027 онд 228.0 хувиар буюу 3.3 дахин нэмэгдэж эрс өсөхөөр байгаа юм.

Хүснэгт 3. Цалин, тэтгэвэр, шилжүүлгийн өсөлт

Үзүүлэлт	2026 оны тодотгол тэрбум төг.	2027 оны төсөл тэрбум төг.	Өөрчлөлт, тэрбум төг.	Өөрчлөлтийн хувь
Цалин, хөлс	7,687.8	9,190.3	+1,502.5	19.5
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,779.8	9,070.4	+2,290.6	33.8
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2,592.0	2,737.1	+145.0	5.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	509.0	1,670.4	+1,161.4	228.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	157.2	484.9	+327.7	208.6

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн танилцуулга

Тэтгэвэр, тэтгэмж, иргэдэд олгох шилжүүлгийн өсөлтийг нийгмийн хамгааллын бодлогын зорилт, хамрагдах хүн амын тоо, нэг хүнд ногдох дэмжлэгийн хэмжээ, инфляц, ядуурал болон өрхийн бодит орлогод үзүүлэх нөлөөтэй уялдуулан авч үзэх шаардлагатай байна.

3.6. Төрийн албан хаагчдын цалин хөлсний нэгдсэн бодлогыг төсвийн орлоготой бус эдийн засгийн нөхцөл байдал, бүтээмжтэй уялдуулан тодорхойлох нь чухал. Цалин хөлсний зардлыг 2027 онд 9,190.3 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь 2026 оны тодотгосон дүнгээс 1,502.5 тэрбум төгрөгөөр буюу 19.5 хувиар нэмэгдэхээр байна. Төсвийн төсөлд төрийн албан хаагчдын цалингийн сүлжээг нэмэгдүүлэх арга хэмжээнд нийт 211.6 мянган төрийн албан хаагчийг хамруулахаар тусгажээ. Мөн тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулан ирэх онд 10 хувиар нэмэгдүүлэхээр тооцсон байна. Засгийн газраас цалин хөлсний нэгдсэн бодлого боловсруулж мөрдүүлэх, ялгавартай байдлыг арилгах талаар санаачилга гарган ажиллаж байгаа ч цалин хөлсний зардлын өсөлт нь төсвийн төдийгүй эдийн засгийн томоохон асуудал болох шинжтэй байна.

Цалин хөлсний зардал 2023 онд 40 хувь, 2024 онд 131 хувь, 2025 онд 16 хувь өссөн бол 2026 оны тодотгохоор өргөн мэдүүлсэн саналд 24 хувь, 2027 онд 20 хувиар өсөхөөр байна. Иймээс цаашид төрийн албан хаагчдын цалин ижил хувиар нэмэгдүүлэх зарчмаар бус, төрийн албан хаагчдын тоо, ажлын байрны хэрэгцээ, ажлын бүтээмж, үйлчилгээний чанар, гүйцэтгэл, үр дүнтэй нь уялдуулахад анхаарч, одоогийн цалин хөлсний тогтолцоо, хэрэгжүүлж буй бодлогыг эргэн харах шаардлагатай. Энэ нь төсвийн зарлагын үр ашиг, үр

дүн болон дунд хугацааны төсвийн тогтвортой байдлын хувьд ач холбогдолтой гэж үзэж байна.

3.7. Төрийн албан хаагчдын үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний зардал дунд хугацаанд нэмэгдэх хандлагатай байна. Тооцооллын үр дүн (хавсралт 3)-ээс харахад, 2028-2029 онд үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний зардлыг зөвхөн инфляцын өсөлтөөр нэмэгдүүлсэн тохиолдолд өсөлт харьцангуй тогтвортой байх боловч ДНБ-ий бодит өсөлтийг давхар тусгасан хувилбар болон сүүлийн 10 жилийн дундаж өсөлтийн хурдаар тооцсон хувилбарт зардлын өсөлт илүү өндөр байна. Ялангуяа сүүлийн 10 жилийн дундаж өсөлтийн хурдаар тооцсон хувилбарт үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний зардал нийт зардлын 2028 онд 24.6 хувь, 2029 онд 29.2 хувийг эзлэхээр байгаа нь өмнөх жилүүдийн өндөр өсөлтийн хандлага цаашид үргэлжилбэл төсөвт үүсэх дарамт ихээхэн нэмэгдэхийг харуулж байна. Иймд төрийн албан хаагчдын цалин хөлсний хэт өсөлт нь цаашид төсвийн бодлогын гол эрсдэл төдийгүй хувийн хэвшилд дарамт болох хандлагатай байгааг анхаарах шаардлагатай.

3.8. Төсөвт эзлэх тэтгэврийн зардал зөвхөн 2027 онд төдийгүй 2028, 2029 онд ч нэмэгдэхээр байна. Өндөр настны тэтгэврийн зардлыг зөвхөн инфляцад суурилан тооцвол 2028 онд 6,219.4 тэрбум, 2029 онд 6,592.5 тэрбум төгрөгт хүрэх бөгөөд энэ нь нэгдсэн төсвийн нийт зардлын 14.7-14.9 (хавсралт 3) хувийг эзэлж жил бүр нэмэгдэхээр байна. Энэ хандлага нь тэтгэврийн шинэчлэлийг хурдасгах, төр хариуцах зардлыг бууруулах арга хэмжээ авах шаардлага үүсгэж байна.

3.9. Улсын төсвийн 9 ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн төсвийн зардал 2020-2027 оны дунджаар төсвийн нийт зардлын 85.3 хувийг эзэлж байгаа нь төсвийн зарлагын гол ачаалал нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, санхүү, хууль зүй, батлан хамгаалах, зам тээвэр, эрчим хүч, соёл, спорт, аялал жуулчлалын салбарт ногдож буйг илтгэж байна. Улсын төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн зардал 2027 онд 7.9 их наяд төгрөг буюу 33 хувиар өсөж байгаа бөгөөд үүний 87.2 хувийг эдгээр 9 ТЕЗ-ийн зардал бүрдүүлж байна. 2021-2025 онд өсөлт 15 хувь орчим байв. Ирэх оны төсвийн зарлагын өсөлтөд гол нөлөө үзүүлж байгаа ТЕЗ-ийн төсвийн зардлыг авч үзвэл, Боловсролын сайд 2,044.4 тэрбум төгрөг буюу өсөлтийн 25.7 хувь, Сангийн сайд 1,230.2 тэрбум төгрөг буюу 15.5 хувь, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 1,190.9 тэрбум төгрөг буюу 15.0 хувь, эрчим хүчний сайд 675.8 тэрбум төгрөг буюу 8.5 хувь, Эрүүл мэндийн сайд 573.1 тэрбум төгрөг буюу 7.2 хувь, Хууль зүй, дотоодын хэргийн сайд 478.8 тэрбум төгрөг буюу 6.0 хувь, Зам, тээврийн сайд 476.0 тэрбум төгрөг буюу 6.0 хувь, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд 365.1 тэрбум буюу 4.6 хувь, Батлан хамгаалахын сайд 316.4 тэрбум төгрөг буюу өсөлтийн 4.0 хувьтай тэнцэх зардлыг 2026 оны тодотгохоор өргөн мэдүүлсэн дүнгээс нэмж гаргахаар төсөвлөсөн байна. Улсын төсвийн 2027 оны зарлага, түүний өсөлтийн гол хэсгийг дээр дурдсан ТЕЗ нарын төсвийн багц бүрдүүлж байгаа тул эдгээр ТЕЗ-ийн төсвийн зардал болон үр дүнгийн уялдаа нь төсвийн нийт үр дүн, үр ашигт шийдвэрлэх ач холбогдолтой юм.

3.10. Төсвийн зарлагын үр дүн, үр өгөөжийг тодорхойлоход хүндрэлтэй, шаардагдах мэдээлэл хангалтгүй хэвээр байна. Төсвийн төслийн танилцуулгад “зарцуулалт бүрийг хэрэгцээ, бэлэн байдал, үр өгөөжөөр эрэмбэлнэ” гэсэн зорилт дэвшүүлсэн гэжээ. Иймээс ТТБЗ энэ зарчим бодит төсвийн хуваарилалтад хэрэгжсэн эсэхийг нягталж үзэхийг хичээсэн. 2027 оны төсвийн төсөлд ТЕЗ бүрийн зарцуулах төсөв болон хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тус тусад нь тодорхойлсон боловч

төсвийн зарлагын хэмжээ, түүний бүтэц болон хүрэх үр дүнгийн хоорондын тоон уялдаа, нэгж үр дүнд ногдох төсөв, зарлагын үр ашиг, үр дүнг тооцоход шаардагдах мэдээлэл хангалтгүй хэвээр байна. Түүнчлэн зарим ТЕЗ-ийн хувьд үр дүнгийн үзүүлэлт нь нийгэм, эдийн засгийн бодит үр нөлөөг хэмжихэд ойр байгаа бол зарим нь орц буюу нөөц, зарим нь үйл ажиллагаа, арга хэмжээ, гарцыг хэмжсэн шинжтэй байна. Энэ нь хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн чанар ТЕЗ бүрийн тухайд харилцан адилгүй байгааг харуулна. Үүний зэрэгцээ хөрөнгийн зардал өндөртэй зам, тээвэр, эрчим хүч, боловсрол, хот байгуулалт, барилга, орон сууцжуулалт зэрэг салбарын ТЕЗ-ийн хувьд хөрөнгө оруулалтын зарцуулалт болон бий болох хүчин чадал, үйлчилгээ, эдийн засгийн үр өгөөжийн уялдааг тусгайлан үнэлэхэд шаардагдах шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, хэрэглэх нь чухал.

4. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР

4.1. УИХ-аас баталсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах хэрэгтэй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтийг сайжруулах асуудлаар УИХ-аас удаа дараа тогтоол, шийдвэр (хавсралт 2) гарган Засгийн газарт үүрэг даалгавар өгч ирсэн. Эдгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, биелэлтийг Монгол Улсын Засгийн газраас тодруулга, тайлбар, тайлан хэлбэрээр авч занших нь төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд эерэг нөлөөтэй.

4.2. Төсвийн нийт хөрөнгө оруулалтыг нэрлэсэн ДНБ-тай харьцуулсан харьцаагаар авч үзвэл хөгжиж байгаа орнуудын жишгээс хоёр нэгж хувиар илүү байгаа ч хөрөнгө оруулалтын үр ашиг, чанарт анхаарах шаардлагатай. 2027 оны нэгдсэн төсвийн төслөөр нийт 10.3 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй үүнээс тайлант онд 5.77 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 815 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Хүснэгт 4. Монгол Улсын 2017-2027 оны нэгдсэн төсөвт эзлэх хөрөнгө оруулалтын зардлын гүйцэтгэл болон ДНБ-д эзлэх дүн, тэрбум төгрөгөөр


№	Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	2025	2026	2026	2027
		гүйц.	гүйц.	гүйц.	гүйц.	гүйц.	гүйц.	бат.	тод.	төсөв.
Хөрөнгийн зардал		3,034.2	2,982.2	3,803.4	5,188.2	7,970.8	7,074.0	8,568.5	8,414.4	10,333.3
1	Барилга байгууламж	2,072.0	1,941.1	2,923.5	3,730.3	5,355.3	5,158.1	3,649.0	3,447.1	6,563.9
2	Их засвар	145.0	128.5	142.9	172.3	314.7	381.2	172.4	165.0	309.5
3	Тоног төхөөрөмж	-	-	-	-	-	-	664.5	591.4	415.9
4	ТЭЗҮ-Зураг төсөв	-	-	-	-	-	-	28.4	17.6	35.5
5	Цахим систем	-	-	-	-	-	-	13.1	3.5	8.8
6	Бусад хөрөнгө	817.3	912.7	737.0	1,285.6	2,300.7	1,534.7	4,006.6	4,155.2	2,983.1
7	Стратегийн нөөц хөрөнгө	-	-	-	-	-	-	34.6	34.6	16.6
ДНБ		36,958.6	42,133.5	53,505.3	70,441.5	79,956.3	89,937.1	102,400.0	102,400.0	115,300.0
ДНБ-д эзлэх хувь		8.2	7.1	7.1	7.4	10.0	7.9	8.4	8.2	9.0

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн хөрөнгө оруулалтын тайлант онд санхүүжих 5.77 их наяд төгрөгийн 3.77 их наядыг улсын төсвөөс, 2.0 их наядын санхүүжилтийг Оюутолгой ХХК-ийн 2027 онд орж ирэх ногдол ашгаар хийхээр тус тус төлөвлөсөн. ОУВС-ийн хийсэн эмпирик судалгаагаар

хөгжиж байгаа орнуудын төсвийн нийт хөрөнгө оруулалтын ДНБ-д эзэлж буй хувь 5-7 байвал зохистой хэмжээнд байна гэж дүгнэсэн¹. Энэхүү судалгаатай жишиж үзвэл манай улсын хувьд хөрөнгө оруулалтын хэмжээг ДНБ-д харьцуулсан харьцаа нь хөгжиж буй орнуудын дунджаас 2 хувиар илүү байна. Гэхдээ хөрөнгө оруулалтын нийт хэмжээнээс илүүтэйгээр хөрөнгө оруулалтын төлөвлөлт, үр ашиг, чанарт анхаарах шаардлагатай юм.

Зураг 7. Монгол Улсын 2017-2027 оны нэгдсэн төсөвт хөрөнгө оруулалтын зардлын эзлэх хувь



4.3. Төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, чиглэл нь зөв байгаа ч хэрэгжилт, үр дүнд нь анхаарах шаардлагатай. Улсын төсвөөр санхүүжих төсвийн хөрөнгө оруулалтын дийлэнх буюу 46.6 хувийг дэд бүтэц, 29.8 хувийг боловсролын салбарт тус тус зарцуулахаар төлөвлөж байна. Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд 815 төсөл, арга хэмжээнд 5,773.8 тэрбум төгрөгийг төсөвлөснөөс улсын төсвийн 3,773.8 тэрбум төгрөгөөр 763 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнээс 617 нь буюу 80 хувь нь дэд бүтэц, боловсрол, эрүүл мэндийн салбарт ногдож байгаа нь бодлогын хувьд зөв алхам гэж үзэж байна.

Хүснэгт 5. 2027 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тоо, санхүүжилтийн дүн, салбараар, тэрбум төгрөг

№	Салбараар	Төслийн тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Эзлэх хувь
1	Дэд бүтэц	226	6,171.5	1,758.5	46.6
2	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	346	3,459.6	1,125.3	29.8
3	Эрүүл мэнд	45	559.2	163.8	4.3
4	Төрийн төв байгууллагууд	70	1,057.0	415.4	11.0
5	Хууль сахиулах, батлан хамгаалах	52	431.1	235.4	6.2
6	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй	24	160.6	75.5	2.0
Нийт дүн		763	11,839.1	3,773.8	100.0

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл

4.4. Оюутолгой төслийн ногдол ашгаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтад томоохон байр суурь эзэлж байна. Оюутолгой төслийн ногдол ашиг болох 2,000.0 тэрбум төгрөгөөр 52 төсөл санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь 2027 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 34.6 хувийг эзэлж байна.

¹ Олон улсын валютын сан (ОУВС), [Chapter 2], IMF eLibrary, <https://www.elibrary.imf.org/display/book/9781513511818/ch002.xml>.

Хүснэгт 6. Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, тэрбум төгрөгөөр

Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт	2027 онд санхүүжих дүн	Төслийн тоо
	5,773.8	815
Улсын төсөв	3,773.8	763
Оюутолгой ХХК	2,000.0	52

Оюутолгойн хөрөнгөөр санхүүжих томоохон төслүүдээс дурдахад дулааны цахилгаан станц VI-ийн 300 МВт-ын хөрөнгө оруулалтад 400.0 тэрбум төгрөг, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж, ашиглалтын зардал болон байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулан, ухаалаг шийдлийг үе шаттай нэвтрүүлэх “Ногоон, ухаалаг сургууль” төсөлд 240.7 тэрбум төгрөг, боловсролын салбарын сургалтын орчин, тоног төхөөрөмжийн хүртээмжийг сайжруулах төсөлд 75.0 тэрбум төгрөг, Ханги хилийн боомтын шинэчлэлд 63.6 тэрбум төгрөг, Жаргалант-Шинэ-Идэр-Мөрөн чиглэлийн хатуу хучилттай авто замын төсөл (151.5 км) 61.0 тэрбум төгрөг, Арцсуурь хилийн боомтын шинэчлэлд 51.8 тэрбум төгрөг, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад 50.0 тэрбум төгрөг төсөвт тусгасан. Иймд Оюутолгой төслөөс авах ногдол ашгийн хэмжээг Монгол Улсын Засгийн газар болон Рио Тинто компани албан ёсоор харилцан баталгаажуулах нь 2027 онд эдгээр төслийг хэрэгжүүлэх урьдач нөхцөл болно.

4.5. Улсын нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 3 жилээс дээш хугацаанд хэрэгжиж буй төслүүд улсын төсвийн хөрөнгийн зардлын 16.7 хувийг эзэлж байгаа тул төсвийн хөрөнгө оруулалтын үр ашиг, гүйцэтгэлд онцгой анхаарах шаардлагатай. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь заалтын дагуу шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж дуусгах ёстой байдаг. Гэтэл 3 жилээс дээш хугацаанд хэрэгжиж буй нийт 154 төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн нийт хөрөнгийн санхүүжилтийн 16.7 хувийг эзэлж байна. Мөн эдгээр төсөл, арга хэмжээний анхны төсөвт өртгийг тайлант оны төсөвт өртөгтэй харьцуулахад 31.7 хувиар өссөн дүнтэй байна.

Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгөөр 3 жилээс дээш жил хэрэгжиж буй төсөл арга хэмжээний мэдээлэл

Он	ТАХ-ний үргэлжилсэн хугацаа	Төсөл, арга хэмжээний тоо	Анхны төсөвт өртөг	2027 оны төсөвт өртөг	2027 онд санхүүжих дүн
2012	15	1	7.1	26.1	0.9
2013	14	2	25.0	137.1	27.5
2018	9	10	29.7	53.1	8.4
2019	8	25	112.3	176.0	34.0
2020	7	20	240.5	482.5	87.4
2021	6	19	101.2	184.5	47.8
2022	5	66	932.9	1,218.5	265.0
2023	4	1	138.4	135.6	1.1
2024	3	10	778.7	704.1	156.6
Нийт дүн		154	2,365.6	3,117.5	628.7

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёрдугаар хавсралт

4.6. Төсөвт өртөг нь ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн, томоохон төсөл, арга хэмжээнүүдийг УИХ-аас төсвийн төслийн хэлэлцүүлгийн үеэр тусгайлан анхаарч, нэмэгдсэн шалтгааныг тодорхойлох шаардлагатай. Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний дотор төсөвт өртөг нь анхныхаасаа 81.7 хувиар нэмэгдсэн, нийт 3.4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 165 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалтаас харахад дийлэнх хувь нь барилга, дэд бүтцийн салбарт хамаарч байгаа бөгөөд УАГ-аас өмнөх онуудад төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлтээр төслийн гүйцэтгэл удааширч хугацаа нь сунах, төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг судалгаа, тооцоо муутай хийх, тендерт шалгарсан компаниуд анхнаасаа зөвхөн ялах зорилгоор тендерийн төсөвт өртгөөс бага дүнтэй санал ирүүлээд цаашид төсвөө нэмүүлдэг гэх мэт шалтгааныг дурдсан байдаг².

Хүснэгт 8. Монгол Улсын 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгагдсан төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл, арга хэмжээ

Үзүүлэлт	Дүн
Төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний тоо	165
Анхны төсөвт өртгийн нийлбэр, тэрбум төг.	1,880.7
Сүүлийн төсөвт өртгийн нийлбэр, тэрбум төг.	3,416.6
Нэмэгдсэн дүн, тэрбум төг.	1,535.9
Анхны өртөгтэй харьцуулахад нэмэгдсэн хувь	81.7

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёрдугаар хавсралт

Иймд цаашид дээрх нөхцөлөөр төсвийн хөрөнгө оруулалтын өртөг нэмэгдэх, гүйцэтгэл тасалдах нөхцөлийг хязгаарлах үүднээс төсвийн хэлэлцүүлгийн хүрээнд төсөвт тусгагдсан хөрөнгө оруулалтуудыг нягтлах шаардлагатай.

5. ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР, ТӨЛБӨРИЙН ТАЛААР

5.1. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл, ДНБ-ий харьцаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөлөлтэй нийцэж байгаа боловч сүүлийн жилүүдэд эрс хурдацтай нэмэгдэж байгаа нь дунд болон урт хугацаанд өрийн эрсдэлд хүргэх нөхцөл бүрдүүлэхээр байна. Засгийн газрын нэрлэсэн нийт өрийн ДНБ-д эзлэх хувь 2022 оноос өмнө Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар мөрдөж буй одоогийн 60 хувиас өндөр явж ирсэн. Монгол Улсын зээлжих зэрэглэл буурч, саарал жагсаалтад орсон 2016 онд нийт өр ба ДНБ-ий харьцаа 93 хувьд, 2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед 75 хувьд хүрч өсжээ. Улмаар 2020 оноос хойш нийт өр ба ДНБ-ий харьцаа тасралтгүй буурах хандлагатай байв. Нийт өр ба ДНБ-ий харьцаа 2026-2027 оны хувьд хуулийн хязгаарын дотор байх хүлээлттэй ч өсөх төлөвтэй байна.

Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийн хэмжээ болон ДНБ-д эзлэх хувь 2025 оны жилийн эцсийн байдлаар 35.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 39.4 хувь³, 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 45.6 их наяд төгрөг буюу 44.5 хувь⁴, 2027 оны төсөөллөөр 56.6 их наяд төгрөг болж ДНБ-ий 49.6 хувьд хүрэхээр байна. Эндээс харахад сүүлийн хоёр жилийн дотор

² Эдгээр зөрчлийг УАГ-ын 2017, 2018, 2019, 2023 оны гүйцэтгэлийн аудитын тайлангуудад удаа дараа онцлон дурдаж байв.

³ Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгын 32-р хуудас.

⁴ Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгын 114-р хуудас.


Засгийн газрын өрийн үлдэгдэл 21.2 их наяд төгрөг буюу ДНБ-д эзлэх хувь 14.2 хувиар эрс нэмэгдэх, Засгийн газрын өрийн үлдэгдэл 2027 онд 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 11.0 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр байна.

Зураг 8. Нийт өр, ДНБ-ий харьцаа ба хуулийн хязгаар



Эх сурвалж: ҮСХ, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл

Зураг 9. Засгийн газрын өр, тэрбум төгрөг, ДНБ-д өрийн эзлэх хувиар




Эх сурвалж: ҮСХ, 2027 оны төсвийн төсөл

Үүний гол шалтгаан нь урьд өмнө гэрээ, хэлэлцээр байгуулсан гадаад зээлийн ашиглалт 1.4 их наяд төгрөг, Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа 2 их наяд төгрөг, орон нутгийн үнэт цаас нэмж гаргахтай холбоотой 0.6 их наяд төгрөг, Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслүүдийн зээлийн ашиглалт 2.5 их наяд төгрөг, эрчим хүчний салбарт шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэхэд 1.1 тэрбум ам.доллар, нийслэлийн олон улсын зах зээлд гаргасан 500 сая ам.долларын дахин санхүүжилттэй холбоотой Засгийн газрын өрийн баталгаа гаргах явдал болж байна. Энэ байдал буюу жил бүр засгийн газрын өрийн үлдэгдэл 10 их наяд төгрөгөөр нэмэгдэж байгаа нь 2015-2017, 2019-2020 оны нөхцөл байдал давтагдах эрсдэл байгааг харуулж байна.

Нөгөө талаар Засгийн газрын өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцааг Дэлхийн банкны орлогын ангиллаар ижил төстэй буюу дундаас дээгүүр орлоготой 20 улстай жишиж үзэхэд БНХАУ, Малайз, Тайланд, Филиппинд ДНБ-ий 60-112.5 хувьтай байгаа бол,

Албани, Мьянмар, Чили, Монгол улсад ойролцоо буюу 40-60 хувийн хооронд, харин Вьетнам, Нигери, Азербайжан, Казахстан, Гүрж, Узбекистан, Перу улсад 20-40 хувийн орчим хэлбэлзэж байна. Гэхдээ эдгээр оронтой харьцуулахад сүүлийн хоёр жилийн хугацаанд манай улсын энэ харьцаа өсөх хандлагатай байгаа нь анхаарал татаж байна.

Зураг 10. Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь, Дэлхийн банкны орлогын ангиллаар дундаас дээгүүр орлоготой 20 оронтой харьцуулсан байдал



Эх сурвалж: ОУВС, https://data.imf.org/en/datasets/IMF.RES:WEO?indicator_id=GGXWDG_NGDP, Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн танилцуулга, хуудас 114.

5.2. Засгийн газрын нийт өр болон өрийн үйлчилгээний динамикийг дотоодын болон олон улсын босго утгуудтай харьцуулж үзэхэд 2026-2027 онд хязгаарын дотор байх хүлээлттэй байгаа боловч улсын төсвийн зарлагад өрийн үйлчилгээний төлбөрийн эзлэх дүн нэмэгдэж, тодорхой дарамт учруулахаар байна.

Зураг 11. Гадаад өрийн үйлчилгээ, төсвийн тэнцвэржүүлсэн орлогын харьцаа ба сэрэмжлүүлэх түвшин



Эх сурвалж: Сангийн яам, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл

ОУВС болон Дэлхийн банкнаас бага орлоготой улсуудын өрийн дарамтыг үнэлэх шалгуур үзүүлэлт болон босго утгыг тогтоосон байдаг⁵. Манай улс бага орлоготой улсын ангилалд хамаарахгүй ч бага орлоготой улсуудад хэрэглэгдэж буй өрийн эмзэг байдлыг үнэлэх голлох шалгуур үзүүлэлт болох Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээ, төсвийн тэнцвэржүүлсэн орлогын харьцаа ОУВС-ийн сэрэмжлүүлэх түвшнээс 2020-2021, 2023 онд давсан бол бусад жилд энэ хязгаарын дотор байна. Засгийн газрын өрийн үйлчилгээ буюу үндсэн өр, хүүгийн төлбөрийн хэмжээ зохистой хязгаарын дотор байгаа боловч тэнцвэржүүлсэн нийт орлогын 10 хувьд ойр байна. Монгол Улсын 2027 оны нэгдсэн төсвийн төсөлд тусгагдсанаар Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөр 5.2 их наяд төгрөг болохоор байгаа нь 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл (3.2 их наяд төгрөг)-тэй харьцуулахад 60.5 хувиар өсөж, төсвийн урсгал зардалд болон гадаад валютын нөөцөд тодорхой дарамт учруулахаар байна. Засгийн газрын гадаад бондын үндсэн өрийн төлбөр 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 71.4 тэрбум төгрөг байх бол 2027 онд 1.6 их наяд төгрөгт хүрэхээр байна.

Зураг 12. Гадаад өрийн үйлчилгээ, экспортын орлогын харьцаа ба сэрэмжлүүлэх түвшин



Эх сурвалж: Сангийн яам, Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл


Харин зээлийн хүүгийн төлбөр 2026 онд 1.3 их наяд төгрөг, 2027 онд 1.6 их наяд төгрөг байхаар байна. Энэ нь Төсвийн нийт зарлагын 11.9 хувь, урсгал зарлагын 15.5 хувьтай тус тус тэнцэж байна. Жил ирэх тусам Засгийн газрын гадаад, дотоод зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдэж байгаа нь төлбөрийн чадварт сөрөг үр дагавар үүсгэхээр байна. Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээг экспортын орлогод харьцуулсан харьцаа 2021 оноос бусад хугацаанд ОУВС-ийн сэрэмжлүүлэх түвшнээс доогуур буюу шаардлагыг хангасан байна.

5.3. Засгийн газрын нийт өрд эзлэх гадаад өрийн хэмжээ тогтмол өндөр буюу 2018-2025 оны дунджаар 96 хувьтай байгаа нь валютын ханшаар дамжин төсөвт тодорхой эрсдэл учруулахаар байна. Засгийн газрын өрд эзлэх гадаад өрийн үлдэгдлийн хэмжээ өсөх нь өндөр эрсдэлийг дагуулна. Наад зах нь гадаад зээлийн өрийн үлдэгдэл ханштай шууд холбоотой байдаг учраас ханш ихээхэн хэмжээгээр сулрах нь өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцааг шууд ихэсгэнэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл, гадаад өрийн түвшин өндөр


⁵ Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)/ДНБ=55, Засгийн газрын гадаад өр (ӨҮЦ)/ДНБ=40, Засгийн газрын гадаад өр (ӨҮЦ)/экспорт=180, Гадаад өрийн үйлчилгээ/төсвийн орлого=18, Гадаад өрийн үйлчилгээ/экспорт=15 <https://www.imf.org/en/about/factsheets/sheets/2023/imf-world-bank-debt-sustainability-framework-for-low-income-countries>

байх нь ханшийн савлагаанаас үүдэлтэй өрийн дарамт, эмзэг байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдлийг валютаар ангилбал ам.доллар 56.5 хувийг, зээлжих тусгай эрх 19.7 хувийг, иен 11.6 хувийг, евро 7.3 хувийг, вон 4.8 хувийг, Кувейт динар 0.1 хувийг тус тус эзэлж байна. Эдгээрээс голлох 3 валютын ханшийг авч үзвэл 2018-2021 онд жилд дунджаар ам.долларын ханш 4 хувь, еврогийн ханш 5 хувь, иений ханш 5 орчим хувиар тус тус суларсан.

Зураг 13. Гадаад зээлийн үлдэгдэл, валютаар




Зураг 14. Засгийн газрын гадаад, дотоод өрийн нийт өрд эзлэх хувь



Эх сурвалж: 2027 оны төсвийн танилцуулга

Эх сурвалж: Сангийн яам

Зураг 15. Төгрөгийн ам.доллар, иен, евро зэрэг валюттай харьцах ханшийн өсөлт, хувиар



Эх сурвалж: Монголбанк

Энэ хугацаанд нийт өрд эзлэх гадаад өрийн хэмжээ 93-97 хувь болж нэмэгдсэн ба 2023 онд ам.долларын ханш 10 хувь, еврогийн ханш 13 хувь сулрах үед гадаад өрийн нийт өрд эзлэх хувь 99 болсон. 2026 оны 8 сарын байдлаар иен 5.6 хувиар чангарч, доллар 1.3 хувь, евро 5.8 хувиар тус тус суларсан нь өмнөх онтой харьцуулахад эдгээр валютын сулрах хурд саарсныг илтгэж байна. Нүүрс, зэсийн экспорт сайн байж, гадаад валютын нөөц нэмэгдсэн нь ханшид эергээр нөлөөлж байгаа ч цаашид ханшийн эрсдэлийг бууруулахын тулд гадаад өрийн хэмжээг бууруулахад анхаарах нь зүйтэй.

5.4. Төсвийн танилцуулгад Засгийн газрын өрийн багцын зардал, эрсдэлийн үзүүлэлтийг 2025 оны хувьд тооцож үзэхдээ ханшийн эрсдэлээс бусад эрсдэл (өрийн хүү, дахин санхүүжилт) буурч байгааг дурдсан ч цаашдын хандлагыг анхаарах нь

зүйтэй. Геополитикийн зөрчилдөөний улмаас дэлхий нийтээр үнийн өсөлт эрчимжиж, төв банкуудын хүү өндөр түвшинд хадгалагдах эрсдэл нэмэгдэж байгаа нь дунд, урт хугацаанд суурь хүү нэмэгдэх замаар өрийн зардлыг өсгөх нөлөө үзүүлж болзошгүй байна. Төсвийн танилцуулгад дурдсан дунд хугацааны өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр “Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээ дараагийн 5 жилд өсөхөөр гарсан байх бөгөөд энэ нь гадаад зээлийн ашиглалт өсөх, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өсөх зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж байна. Хэдий үзүүлэлт муудсан ч төсвийн алдагдал болон үндсэн төлбөрийн хэмжээ ДНБ-тэй харьцуулахад бага байх тул эрсдэлийн түвшин бага байна”⁶ гэж үзжээ. Харин ОУВС-ийн эрсдэлийн үнэлгээгээр цалин, тэтгэвэр зэрэг байнгын шинжтэй зардлууд өсөх нь дунд, урт хугацааны Засгийн газрын өрийн эрсдэлийг нэмэгдүүлэхээр байна⁷ гэж дүгнэжээ. Иймд төсвийн алдагдал, өрийн хэмжээ, урсгал зардлын өсөлт зэргийг харгалзан ирээдүйд тулгарч болзошгүй өрийн эрсдэлийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

5.5. Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл буюу болзошгүй өр төлбөрийн ДНБ-д эзлэх хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь улсын төсөвт тодорхой хэмжээний эрсдэл учруулахаар байна. Засгийн газрын өрийн баталгааны ДНБ-д эзлэх дүнг дунд хугацаанд 10 хувиас хэтрүүлэхгүй гэж “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг”-д тусгасан ч 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 3.9, 2027 онд 7.5 хувь байхаар тооцож байгаа нь цаашид болзошгүй өр төлбөр дараагийн жилүүдэд өсөх, Засгийн газрын өрийн үлдэгдэл болон төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхөөр байна. Ялангуяа, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэхэд төсвийн эх үүсвэрийг ашиглахаас гадна олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын баталгааг ашиглаж зах зээлээс хөрөнгө оруулалт татах, тухайн төслүүдийн санхүүжилт тасарсан тохиолдолд хөрөнгө оруулагчдад Засгийн газраас нөхөн олгохоор тооцоолж байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.

5.6. Орон нутгийн үнэт цаасны үлдэгдлийг хянаж, удирдах шаардлага тулгарч байна. Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт орон нутгийн үнэт цаасны үлдэгдлийг тухайн аймаг, нийслэлийн орлогод харьцуулсан харьцааг 2027 онд 60 хувь байхаар хязгаарласан нь зүйтэй боловч нийслэлийн хувьд энэ харьцаа 2027 онд 59.3 хувьтай тэнцэхээр байгаа нь эрсдэлийг үүсгэж болзошгүй. Нийслэлийн ирэх оны төсвийн орлого тасалдах, валютын ханш сулрах зэрэг хүндрэл үүсэх тохиолдолд Засгийн газар, улсын төсөв эцсийн зээлдэгчид төлөх үндсэн өр, хүүгийн төлбөрийг хариуцах бөгөөд энэ нь төсвийн зардалд болон гадаад валютын нөөцөд тодорхой дарамтыг учруулахаар байна.

5.7. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг нэмэгдүүлэх, санхүүжилтийн хэрэгцээг хангах, энэ эх үүсвэрээр 2027 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэх нь эдийн засагт эерэг болон сөрөг үр дагаврыг дагуулна. Засгийн газар дотоод үнэт цаасны арилжааг идэвхжүүлж, санхүүжилтийн хэрэгцээний 40 орчим хувийг дотоодоос бүрдүүлэх замаар⁸ 2027 оны нэгдсэн төсвийн алдагдлыг нөхөх, улмаар нийт өрд гадаад өрийн эзлэх жинг бууруулах зорилт тавьсан нь сайшаалтай. Гэвч үүний эдийн засагт үзүүлэх нөлөө нь тухайн эх үүсвэрийг ямар зардалд хуваарилахаас шууд хамаарна. Хэрэв уг хөрөнгийг үр ашигтай хөрөнгө оруулалтын төслүүдэд зарцуулбал нийт эрэлт болон үйлдвэрлэлийг тэлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих чухал хөшүүрэг болно.

⁶ Монгол Улсын 2027 оны төсвийн дэлгэрэнгүй танилцуулга, 141 дүгээр хуудас

⁷ Mongolia: 2026 Article IV Consultation Discussions-Press Release; and Staff Report

⁸ Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгын 118-120-р хуудас

Харин импортыг санхүүжүүлбэл өсөлтөд үзүүлэх нөлөө нь багасгахаас гадна валютын ханшид дарамт үүсгэнэ. Нөгөө талдаа, цалин, тэтгэвэр, халамж зэрэг урсгал зардлыг санхүүжүүлж эхэлбэл богино хугацаанд хэрэглээний эрэлтийг өдөөх боловч хэтэрвэл хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг шахах, төсвийн өрийн үйлчилгээний ачааллыг нэмэгдүүлж, дунд, урт хугацаанд төсвийн орон зайг хумих эрсдэлтэй. Түүнчлэн Засгийн газрын үнэт цаасыг нэмж гаргах нь нь мөнгөний нийлүүлэлтийг шууд тэлэхгүй ч төсвийн зарлагаар дамжин эрэлтийг хөөсрүүлдэг. Энэ нь арилжааны банкны санхүүжилт болон Төв банкны зохицуулалттай уялдсанаар зээл, инфляц, хүүгийн түвшин болон валютын ханшид бодит нөлөө үзүүлэх суурь нөхцөл болно.


Нэгтгэн дүгнэвэл:

- 1) Эдийн засгийн өсөлт, гадаад валютын ханш, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, олон улсын зах зээл дэх хүүгийн түвшин, гадаад санхүүжилтийн хэрэгцээ шаардлага, болзошгүй өр төлбөр зэрэг төрөл бүрийн сөрөг нөлөөлөлд Засгийн газрын өрийн эмзэг байдал хадгалагдсан хэвээр байна.
- 2) Эдийн засгийн өсөлт, төсөв, мөнгөний бодлогын төгрөгийн ханшид нөлөөлөхүйц эмзэг байдал, гадаад эдийн засгийн орчны тодорхой бус нөхцөл өндөр байгаа нь Засгийн газрын өрийг ДНБ-тэй харьцуулсан хувь өсөх нөхцөлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлт хүлээлтэд хүрэхгүй байх эсвэл бодит ханш эрчимтэй сулрах тохиолдолд Засгийн газрын өр/ДНБ харьцаа дунд хугацаанд өсөх хандлагатай байна.
- 3) Засгийн газрын өрийн үлдэгдэл хурдацтай өсөж байна. Энэ байдал дараа дараагийн жилүүдэд үргэлжилбэл Засгийн газрын өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагатай нийцэхгүй болж, өрийн дарамтад орох эрсдэлтэй нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4) Засгийн газрын өр хурдацтай нэмэгдэж байгаа үед өрийн үлдэгдлийн хэмжээ нь өрийн үйлчилгээний төлбөр нэмэгдэхэд шууд нөлөөлж байна. Энэ нь улсын төсвийн зардлын ачааллыг нэмэгдүүлж, гадаад валютын нөөцөд дарамт учруулан, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгох эрсдэлтэй.
- 5) Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл буюу болзошгүй өр төлбөр сүүлийн 2 жилийн хугацаанд эрс нэмэгдэж байгаа нь макро эдийн засгийн болон төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулж байна.
- 6) Нийслэлийн үнэт цаасны хөрөнгө оруулалт үр ашиггүй зарцуулагдах тохиолдолд улсын төсөвт ихээхэн дарамтыг бий болгоно. Одоогоор гаргасан 500 сая ам.долларын үнэт цаасны зарим хэсэг нь арилжааны банкнуудад байршиж, тэдгээрийн зээлийн эх үүсвэр байдлаар ашиглагдаж байна. Цаашид орон нутгийн дотоод, гадаад үнэт цаасны эрх зүйн орчныг улам тодорхой болгох шаардлагатай. Засгийн газар 2027 онд олон улсын зах зээлд 500 сая ам.долларыг нийслэлээс 2024 онд гаргасан үнэт цаасыг дахин санхүүжүүлэх зорилгоор гаргах нь Засгийн газрын гадаад үнэт цаас буюу Сенчири бондуудыг дахин санхүүжүүлж байгаа хэлбэрийг орон нутгийн түвшинд авчирч эрсдэлийг улам ихэсгэж байна.
- 7) Засгийн газрын дотоод үнэт цаасыг нэмэгдүүлэн дотоод бондын зах зээлийг хөгжүүлж байгаа нь сайшаалтай хэдий ч төсөв, мөнгөний бодлогод нийцүүлэх, инфляцын дарамтыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг бий болгоход нөлөөтэй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд анхаарах шаардлагатай.

6. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТАЛААР

Засгийн газар эрүүл мэндийн зардлаас үүдэлтэй иргэдийн санхүүгийн эрсдэлийг бууруулах зорилгоор хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эмийн чанар, аюулгүй байдлыг тогтмол хянах, иргэн эмийн зардлаа төлөх боломжгүйгээс эмчилгээгээ тасалдуулж, өвчнөө хүндрүүлсний дараа өндөр өртөгтэй эмнэлгийн тусламж авдаг буруу тогтолцоог өөрчлөх зорилт тавьж байгааг бодлогын зөв алхам гэж үзэж байна. Дараах зургаас харвал 2021 онд ЭМДС хамгийн өндөр буюу 259.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байсан нь цар тахлын үед эмчилгээний зардал огцом өссөн, гүйцэтгэлийн санхүүжилтийн шинэ тогтолцоо эхэлж байсантай холбоотой юм. Харин 2023 оноос ЭМДС-ийн төсөв алдагдалгүй болж, санхүүгийн чадавх нь жилээс жилд тогтвортой нэмэгдэж байна.

Зураг 16. ЭМДС-гийн орлого, зарлага



Эх сурвалж: *legalinfo.mn*

Тухайлбал, таван жилийн өмнө 1.4 их наяд төгрөг байсан сангийн орлого 2027 оны төсвийн төслөөр 3.4 их наяд төгрөгт хүрэхээр байгаа нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх санхүүгийн суурь боломж бүрдсэнийг харуулна. Энэ нь орцод суурилсан санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, олон улсын жишгийн дагуу тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлэх зарчимд шилжсэний үр дүн гэж үзэж болохоор байна.

Улсын хэмжээнд 2026 онд 3.2 сая хүн эрүүл мэндийн даатгалд хамрагдсанаас нийт даатгуулагчийн 72.6 хувь төрөөс шимтгэлийг нь хариуцдаг иргэд (орлогын 15.3 хувь), 23.4 хувь албан журмын даатгуулагчид, 4.0 хувь нь шимтгэлээ өөрөө хариуцан төлөгчид байна. Эрүүл мэндийн даатгалын шимтгэл дэлхийн улс орнуудад 5-37 хувь, харин манай улсад хамгийн доогуур буюу 4 хувь байгаа ч шимтгэлийг ЭМДС-д бүрэн шилжүүлдэг эсэх нь эргэлзээтэй байна. Учир нь, улсын төсөв батлагдах үед шимтгэлийн орлогыг нийт хувийн

болон төрийн албан хаагчдын дундаж цалингаар тооцдог тул гүйцэтгэлээр нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн аваад ЭМДС-д дутуу шилжүүлдэг байх магадлалтай. Өнгөрсөн жил эрүүл мэндийн даатгалын ажил олгогч, ажилтны шимтгэл 164 тэрбум төгрөгөөр тасарсан, түүнчлэн нийгмийн даатгалын орлого энэ оны эхний хагас жилд 101 хувийн биелэлттэй гарсан бол эрүүл мэндийн даатгалын ажил олгогчийн орлого 95.7 хувийн биелэлттэй байгаа зэрэг нь ингэж үзэх үндэслэл юм.

Мөн манай улсын хувьд 10,000 хүнд ногдох эмнэлгийн ор дэлхийн дунджаас гурав дахин өндөр учраас шаардлагагүй хэвтэлтийн тоо буурахгүй, өвчний түүх цахимжаагүйн улмаас хяналтыг бүрэн хийж чадахгүй байгаа зэрэг анхаарах асуудлууд байна.

ЭМДС-ийн 2027 оны төсвийн тухай хуулийн төслөөр санд 3,401.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 3,082.9 тэрбум төгрөгийн зарлага гаргаж, 74.0 тэрбум төгрөгийн эргэн төлөх төлбөр төлөхөөр тусгажээ.

Хүснэгт 9. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн үндсэн үзүүлэлт

Үзүүлэлт	2026 оны төсөв, тэрбум төг.	2027 оны төсөл, тэрбум төг.	Өсөлт
Нийт орлого	2,551.8	3,401.6	33.3
- улсын төсвөөс хариуцах хэсэг	1,312.8	1,961.7	49.4
- ажил олгогч, даатгуулагч болон бусад	1,239.0	1,439.9	16.2
Улсын төсөвт эзлэх хувь	51.4	57.7	6.3
Нийт зарлага	2,273.3	3,082.9	35.6
- үүнээс эмийн үнийн хөнгөлөлт	-	248.8	-
Орлого, зарлагын зөрүү	278.5	318.7	-

Эх сурвалж: ЭМДС-ийн 2026, 2027 оны төсвийн тухай хуулийн төсөл, төслийн танилцуулга

6.1. ЭМДС-ийн 2024-2026 оны төсвийн орлого, зарлагын тэнцэл эерэг гарч зардлын өсөлтийг тогтворжуулах арга хэмжээ үр дүнгээ өгч эхэлсэн байна. Сангийн тэнцэл 2024-2026 онд эерэг гарсан төдийгүй 2027 онд орлого нь зарлагаас 318.7 тэрбум төгрөгөөр давж, эргэн төлөх төлбөрийг тооцсоны дараа ч эерэг тэнцэлтэй байхаар төлөвлөгджээ. Өмнөх жилүүдэд сан алдагдалтай ажиллаж, эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтээ хугацаанд нь бүрэн авч чадахгүй байх нөхцөл давтагдаж байсныг харгалзвал зардлын хэт өсөлтийг хязгаарлах, гэрээний хяналтыг чангатгах, зохистой хэрэглээг дэмжих чиглэлээр авсан арга хэмжээ зохих үр дүнд хүрч ЭМДС-ийн менежмент мэдэгдэхүйц сайжирч байгааг харуулж байна.

6.2. Тусламж, үйлчилгээг бүс нутгийн бодит хэрэгцээнд суурилан худалдан авах, эмийн үнийн хөнгөлөлтийг зорилтот бүлэгт чиглүүлсэн нь бодлогын зөв чиглэл мөн. Иргэд нийт тусламж, үйлчилгээнийхээ дунджаар 65 хувийг, зарим аймагт ердөө 47 хувийг орон нутагтаа авч байгаа нь иргэдэд шууд бус зардал үүсгэж, нийслэлийн эмнэлгүүдийн ачааллыг нэмэгдүүлж байна. Сонгон шалгаруулалтыг эмнэлгийн одоогийн хүчин чадал, өмнөх оны гүйцэтгэлд бус хүн ам, өвчлөл, бүс нутгийн хэрэгцээнд үндэслэн зохион байгуулж, чанар, гүйцэтгэлийн үнэлгээгээр эрэмбэлэн гэрээ байгуулахаар тусгасан нь стратегийн худалдан авалтын зөв хандлага юм. Мөн хөнгөлөлттэй эмийн үнийн дунджаар 40 хувийг иргэд халааснаасаа төлж байгаа нөхцөлд ахмад настан, зорилтот бүлгийн архаг өвчний эмийн хөнгөлөлтөд 248.8 тэрбум төгрөг тусгасан нь санхүүгийн хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн үндэслэлтэй сонголт болжээ.

6.3. Зарлагын өсөлтийн гол шалтгаан цалин хөлсний нэмэгдэл болж байгаа тул нэмэгдсэн санхүүжилт тусламж, үйлчилгээний хүртээмж, иргэний санхүүгийн

хамгаалалтад хэрхэн хөрвөхийг тодорхой болгох шаардлагатай байна. Сангийн зарлага 2027 онд 35.6 хувиар өсөхөөр тооцсоны гол шалтгаан нь эрүүл мэндийн салбарын цалин хөлсний өсөлт болохыг төслийн танилцуулгад дурдсан байна. Цалин хөлс нь тусламж, үйлчилгээний өртгийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг тул түүний өсөлт тарифаар дамжин сангийн нийт зардлыг өсгөх нөлөөтэй. Гэвч тарифын өсөлтийг тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүртээмж, чанарын бодит өөрчлөлттэй холбосон тоон үзүүлэлт төсөлд тусгагдаагүй байна. Энэ нь нэмэгдсэн санхүүжилт даатгуулагчид бодитоор хүрэх үйлчилгээнд бус хөдөлмөрийн болон тогтмол зардалд бүрэн шингэх эрсдэл үүсгэх бөгөөд энэ тохиолдолд зардал өсөх боловч даатгуулагчийн хүртэх үр өгөөж сайжрахгүй.

6.4. Өртгийн өсөлт, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийн хооронд нийцгүй байдал үүсвэл зөрүү нь эрүүл мэндийн байгууллагын өр төлбөр, эцсийн дүндээ даатгуулагчийн нуруун дээр буух эрсдэлтэй байна. Салбарын цалингийн нэмэгдлийн нийт хэрэгцээг 410 тэрбум төгрөгөөр төлөвлөн сангийн 2026 оны төсөвт 185 тэрбум төгрөг тусгаж, үлдэх хэсгийг тарифын шинэчлэл, орон тоо, бүтээмжийн өөрчлөлт, үйл ажиллагааны үр ашгаар нөхөх тооцоо хийжээ. Энэ арга хэмжээ бодитой хэрэгжихгүй бол өртгийн өсөлт санхүүжилтээр бүрэн нөхөгдөхгүй үлдэнэ. Ийм нөхцөлд сангийн зардлыг хумих бодлого тэнцлийг цаасан дээр хангах боловч санхүүжилтийн дутагдлыг эрүүл мэндийн байгууллага руу шилжүүлж, улмаар өр төлбөр хуримтлагдах, тусламж, үйлчилгээ хязгаарлагдах, иргэдээс нэмэлт төлбөр авах хэлбэрээр даатгуулагчийн нуруун дээр буух эрсдэлтэй. Иймд тэнцлийг зөвхөн зардал хумих замаар бус, өртгийн бодит өсөлт, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийцүүлэх замаар хангах шаардлагатай.

6.5. Сангийн орлогын бүтцийг авч үзвэл улсын төсвөөс хараат байдал нэмэгдэж, орлогын тогтвортой байдалд эрсдэл үүсгэж байна. Нийт орлогын 57.7 хувийг улсын төсвөөс хариуцах хэсэг эзэлж байгаа нь 2026 оны 51.4 хувиас 6.3 нэгжээр өссөн үзүүлэлт бөгөөд харин энэхүү шимтгэлийн орлого ердөө 16.2 хувиар нэмэгдэхээр байна. Өөрөөр хэлбэл, сангийн өсөлтийг даатгалын өөрийн эх үүсвэр бус улсын төсвийн шилжүүлэг тэтгэж байна. 2025 оны гүйцэтгэлээр сангийн орлогын төлөвлөгөө 164.8 тэрбум төгрөгөөр тасарч гүйцэтгэл 93.3 хувьтай гарсны гол шалтгаан нь улсын төсвийн санхүүжилт хуваарийн дагуу бүрэн орж ирээгүйтэй холбоотой байсныг бид өмнөх жилийн дүгнэлтдээ дурдаж байсан. Мөн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг иргэдийн хамралт 50 орчим хувьд байгааг нэмэгдүүлэх тодорхой арга хэмжээ, зорилтот түвшин төсөлд тусгагдаагүй байна.

6.6. Сангийн орлого, зарлага тэнцвэртэй, гүйцэтгэл нь үндсэн чиг үүрэгтээ нийцсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, хэт ашиг хуримтлуулахгүй байх, нөгөө талаас зардлыг зөвхөн цалингаар нэмээд байж болохгүй гэсэн санаа. Эмч, ажилчдын цалинг нэмсэн шийдвэр салбарын ажилтнуудын нийгмийн баталгааг хангахад чухал ач холбогдолтой боловч уг нэмэгдлийн тодорхой хувийг ЭМДС-аас гаргахаар зохицуулсан учраас цалингийн зардлаар төсөв нь нэмэгдээд байгаа ч сангийн үндсэн чиг үүрэг болох өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний иргэний хариуцах хувийг бууруулах, хөнгөлөлттэй эмийн нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцыг өргөжүүлэх (ирээдүйн зардлыг хэмнэх), алслагдсан бүс нутгийн болон яаралтай тусламжийн чанарыг сайжруулах зэрэг арга хэмжээнд хөрөнгө хүрэлцэхгүй байх эрсдэл хэвээр байна.

Зөвлөмж

- 1) Цалин хөлсний нэмэгдлээс үүдэх тусламж, үйлчилгээний өртгийн нийт өсөлт болон түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг тулган харуулсан тооцоог төсвийн төслийн хамт танилцуулж, нөхөгдөөгүй үлдэх зөрүүг барагдуулах арга замыг тодорхой болгох, тариф,


гэрээний дүнгийн өсөлтийг тусламж, үйлчилгээний тоо хэмжээ, хүртээмж, чанарын тоон үзүүлэлттэй нягт уялдуулж, нэмэгдсэн санхүүжилт даатгуулагчид хүрсэн эсэхийг хэмжих шалгуурыг гэрээнд тусгаж байх;

- 2) Санхүүжилтийн зөрүүг эрүүл мэндийн байгууллагын өр төлбөр, иргэний нэмэлт төлбөр рүү шилжүүлэхгүй байх зорилгоор эмнэлгийн өр төлбөрийн үлдэгдэл болон иргэд өөрсдөө хариуцан гаргаж буй төлбөрийн үзүүлэлтийг сангийн гүйцэтгэлийн тайланд тогтмол тусгаж, УИХ-д танилцуулж байх;
- 3) Сангийн тэнцлийг зөвхөн зардал хумих замаар бус орлогын суурийг өргөтгөх замаар хангах бодлогын хүрээнд шимтгэлээ өөрөө төлдөг иргэдийн хамралтын зорилтот түвшин, хүрэх арга хэмжээг тодорхойлж, улсын төсвөөс санд шилжүүлэх санхүүжилтийн улирлын хуваарийг батлан мөрдүүлэх, улмаар ЭМДС-ийн гурван жилийн санхүүгийн төсөөлөл, цалин хөлс, эмийн зардал, шимтгэлийн орлогын өөрчлөлтөд суурилсан шинжилгээг төсвийн төслийн бүрдүүлбэрийн нэг хэсэг болгох;
- 4) Улсын эмнэлгүүдийн менежмент муу, төсвийн сахилга батыг байнга зөрчдөг, хэт өндөр үнэтэй худалдан авалт хийдэг, дур мэдэн батлагдсан орон тооноосоо илүү хүн ажиллуулдаг учраас гүйцэтгэлээрээ авсан орлого нь зардлаа нөхөж хүрдэггүйн улмаас 210 тэрбум өр (ердөө 10 эмнэлэг энэ өглөгийн 80 хувийг эзэлнэ) үүссэн байгааг анхааран үзэж зохих шийдэл гаргах;
- 5) Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд сангийн хөрөнгийг арвижуулах, хуримтлал үүсгэх тухай заалт тусгагдаагүй. Тиймээс нийт даатгуулагчдын дийлэнх олонхын шимтгэлийг улсын төсвөөс төлдөг ч хэмжээ нь хэтэрхий бага мөртлөө тэдгээр иргэдийн хэрэглэж буй тусламж, үйлчилгээний өртөг нь сангаас асар өндөр дүнгээр гардаг байдлыг арилгах үүднээс төрөөс шимтгэлийг нь хариуцдаг бүлгийн шимтгэлийн хувь хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан өсгөх;
- 6) Албан журмын даатгалын суурь багцаас давсан өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх зорилгоор сайн дурын нэмэлт даатгалын эрх зүйн орчныг бий болгож, эрсдэл хуваалцах боломж бүрдүүлэх, олон улсын жишгийн дагуу хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй архи, тамхи, хийжүүлсэн ундааны албан татварын тодорхой хувийг шууд ЭМДС-д төвлөрүүлдэг болох;
- 7) Одоогийн мөрдөж буй оношийн хамааралтай бүлгийг задалж, хүнд хөнгөний зэрэглэл тогтоон лавлагаа тусламж, үйлчилгээний ялгаа бий болгох, тусламж, үйлчилгээг оношийн хамааралтай бүлгийн төлбөрийн аргад бүрэн шилжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, бүтээмжийг үнэлж дүгнэдэг, олон нийтэд зарладаг, санхүүжилтийн урамшуулал олгодог тогтолцоонд шилжих;
- 8) Хөнгөлөлттэй эмийн төсвийг нэмдэг ч эмийн үнийн хөөрөгдлийг хязгаарлаж чаддаггүй, чанаргүй эм импортлогддог тул иргэд даатгуулагч байгаад ч санхүүгийн дарамтаас бүрэн гарч чадахгүй байгааг өөрчлөх арга хэмжээ авах;
- 9) Эрүүл мэндийн даатгалын тохиолдол бүрийг үнэлгээжүүлэн иргэдийн цалин, орлогоосоо төлсөн нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн дүнг E-Mongolia дээр бүртгэж, даатгалын тохиолдол бий болсон үед ваучерээр үйлчилдэг, ашиглаагүй ваучерт урамшуулал олгодог тогтолцоонд шилжих, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог амжилттай хөгжүүлсэн Герман, Япон зэрэг орны туршлага манай ЭМД-ын санд тулгараад буй хуурамч нэхэмжлэл, санхүүжилтийн тэгш бус байдлыг арилгаж, хяналтын тогтолцоог сайжруулахад тохиромжтой байж болох учраас судлан нэвтрүүлэх шаардлагатай.

7. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТАЛААР

7.1. Тэтгэврийн реформыг эхлүүлж байгаа ч төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох шаардлагатай. Тэтгэврийн шинэчлэлийн гол зарчим болох олон жил ажиллаж, илүү их шимтгэл төлсөн даатгуулагч илүү өндөр тэтгэвэр авах бодлого хэрэгжүүлж, олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд үе шаттай шилжих хүрээнд 2026 оны 11 дүгээр сараас суурь тэтгэвэр олгож эхлэх нь нийгмийн даатгалын системийг эрүүлжүүлэх реформын эхлэл гэж үзэж байна.

Зураг 17. НДС-гийн орлого, зарлага, тэтгэврийн насны хүн амын өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Эндээс ерөнхий хандлагыг харвал ирэх жилүүдэд НДС-д ирэх дарамт харьцангуй бага байх төлөвтэй ч бодлогын хувьд анхаарах асуудлууд байна. Тухайлбал, манай улсын тухайд нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ олон улсын түвшинтэй харьцуулахад тийм ч өндөр биш, Төв Ази болон хөгжиж буй орнуудын дундаж жишигт багтаж байгаа ч сангийн орлогын 70 орчим хувийг хөдөлмөрийн насны хүн амын 30 хүрэхгүй хувь бүрдүүлдэг, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, чөлөөт уран бүтээлчид зэрэг сайн дурын даатгуулагчдын системд хамрагдах идэвх сул учраас ажил олгогчдод илүү дарамт мэдрэгдэж байгаа юм. Энэ үүднээс цаашид эв нэгдлийн зарчим буюу одоо ажиллаж байгаа залуусын төлсөн шимтгэлээр өнөөдрийн ахмадуудын тэтгэврийг шууд олгодог хуваарилалтын тогтолцоог эргэж харах, тэтгэвэр авагчдын тоо шимтгэл төлөгч залуусаас хурдан өсөж байгаа тул тэтгэврийн сангийн зарлага жил ирэх тусам нэмэгдэж, улсын төсвөөс татаас авах хамаарал улам гүнзгийрэх хандлагыг харгалзан үзэх шаардлагатай.

7.2. Бодлогын өөрчлөлт нь зөвхөн ахмад настнуудын орлого, амьжиргааг дэмжихээс гадна цогц асуудал гэдгийг анхаарч өөрчлөлтийг хэрэгжүүлэх шаардлагатай. Суурь тэтгэврийн 11, 12-р сарын санхүүжилтийг төсвийн тодотголоор шийдэж байгаа ч энэхүү шинэчлэлийг бүрэн хэрэгжүүлэхэд жил бүр дор хаяж 1.2 их наяд төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс байнга гаргаж байх шаардлага үүснэ. УИХ-аас 2026 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хуримтлалын

болон өвлөгдөх тогтолцооны шинэчлэлийн эхлэлийг тавьсан хэдий ч сангийн чөлөөт үлдэгдлийг зөвхөн арилжааны банкнуудад хадгаламж хэлбэрээр байршуулах, эсвэл Засгийн газрын бонд авах зэргээр хязгаарлаж байгааг өөрчлөн олон улсын жишгээр хувьцаа, үл хөдлөх хөрөнгө, эдийн засгийн үр ашигтай урт хугацааны томоохон төслүүдэд оруулж, инфляцаас өндөр өгөөж олох менежмент хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.


7.3. Бодлогын өөрчлөлт нь сангийн зарлагын өсөлт, орлогын өсөлтөөс давах болон алдагдлыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлж байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлэх хандлагатайг цаашдын бодлогод анхаарах шаардлагатай байна. Сангийн нийт орлого 2027 онд 7,601.4 тэрбум болж 20 хувиар өсөхөөр төлөвлөгдсөн нь 2020-2025 оны дундаж өсөлтийн хандлагатай (18-31%) нийцэж байна. Тэтгэврийн даатгал (орлогын 81.5 хувь) 20.6 хувиар өсөж, сангийн нийт орлогын өсөлтийн 16.7 нэгжийг дангаараа бүрдүүлж байна. Харин тэтгэмжийн болон ажилгүйдлийн даатгал нэгдсэнтэй холбоотойгоор 587.6-1,027.4 тэрбум болж 74.9 хувиар өсжээ.

Зураг 18. Нийгмийн даатгалын сангийн орлого



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл, тооцооллын хавсралт


Зураг 19. Нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлт, хувиар



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл, тооцооллын хавсралт


Сангийн нийт зардал 6,781.1-9,072.8 тэрбум болж 33.8 хувиар өсөхөөр төсөөлөгдсөн нь өмнөх жилүүдийн дундаж түвшин (15-27 хувь)-ээс мэдэгдэхүйц давсан өндөр өсөлт бөгөөд энэ огцом өсөлтийн гол шалтгаан нь суурь тэтгэвэр юм.

Зураг 20. Нийгмийн даатгалын сангийн зардал



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл, тооцооллын хавсралт

Зураг 21. Нийгмийн даатгалын сангийн зардлын өсөлт, хувиар



Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл, Тооцооллын хавсралт

НДС-ийн тэнцэл 2027 онд 1,471.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахаар байгаа нь өмнөх жилүүдээс харьцангуй өндөр үзүүлэлт бөгөөд сангийн алдагдлыг төсвөөс олгох татаасаар санхүүжүүлэхээр байна.

Хүснэгт 10. Нийгмийн даатгалын сангийн тэнцэл

Үзүүлэлт	2022	2023	2024	2025	2026 тод.	2027*
Нийт орлого	2,668.65	3,507.26	4,434.69	5,231.94	6,348.20	7,601.44
Нийт зардал	3,415.71	4,036.15	5,107.21	5,848.52	6,781.06	9,072.80
Тэнцэл	-747.06	-528.90	-672.52	-616.58	-432.86	-1,471.36
Нийт орлогын өсөлт	0.25	0.31	0.26	0.18	0.21	0.20
Нийт зардлын өсөлт	0.33	0.18	0.27	0.15	0.16	0.34

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл, тооцооллын хавсралт

Санал

Төсвийн төсөлд тусгагдаагүй, шийдвэрлэх шаардлагатай зарим зүйл байна. Үүнд: 2025 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор дундаж тэтгэмжийн өсөлтийн нөлөө, төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулан 6,854 албан хаагчийг чөлөөлсөнтэй холбоотой ажилгүйдлийн тэтгэмжид зарцуулах төсөв, санхүүжилтийн эх үүсвэрийг НДС-гийн 2025 төсөвт тусгаагүй 17.4 мянган даатгуулагчийн 50.0 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 2026 оны төсвөөс олгосноос 2026 оны төсөв энэ хэмжээгээр дутагдаж байгаа ч уг нөлөөллийг 2027 оны төсвийн төсөлд тооцоогүй байна. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1,000.0 мянган төгрөг болгох тохиолдолд тэтгэмж бодох дундаж цалин өсөх бөгөөд үүнээс шалтгаалан тэтгэмжийн зардал 86.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байгааг анхааран үзэх шаардлагатай.

8. ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ТАЛААР

8.1. Баялгийн сангийн удирдлагыг сайжруулах бодлого хэрэгжүүлэхдээ тогтолцооны хувьд анхаарах хэрэгтэй. Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад *“төрийн өмчийн компаниудын засаглал, менежментийг олон улсын стандартад нийцүүлэн хувьцааг нь олон улсын хөрөнгийн зах зээлд арилжаална”* гэж дурдсан нь ирэх жилийн бодлогын үндсэн чиглэл гэж харж байна. Тус зорилтын хүрээнд “Чингис хаан баялгийн сан нэгдэл” ХХК-ийн харьяанд үндэсний хэмжээний хөрөнгө оруулалтын санг 100 хувь төрийн эзэмшлийн компани хэлбэрээр байгуулж, төрийн өмчит компаниудын хувьцааны тодорхой хэсгийг тус санд төвлөрүүлэн олон улсын нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын менежментийн компаниар удирдуулах бэлтгэл ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж эхлээд байна. Төрийн өмчийн компанийн засаглал, менежмент-Баялгийн сангийн удирдлага-Чөлөөлье санаачилга гэсэн тулгуурт бүтэц хамтдаа хэрэгжиж байж сан урт хугацаанд үр ашигтай, тогтвортой ажиллах нөхцөл бүрдэх учраас харилцан хамааралтай зөв тогтолцоо бий болгох шаардлагатай.

8.2. Үндэсний баялгийн сангийн орлого нэмэгдэж байна. ҮБС-ийн орлого 2027 онд 4,980.2 тэрбум төгрөгт хүрэх ба 1,000.0 тэрбум төгрөг нь “Оюутолгой” ХХК-ийн ногдол ашиг юм. Зарлага талдаа Хуримтлалын сангийн тухайн жилийн орлогоос нэг их наяд төгрөгийг ГБХНХ-ын сайдын багцад тусгажээ. ҮБС-ийн тухай хуульд заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос Төсвийн тогтворжуулалтын сан, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилсны дараа үлдэх орлогоос 2,930.8 тэрбум төгрөгийг Ирээдүйн өв санд, мөн хуулийн дагуу уул уурхайн олборлолт, ашигт малтмал боловсруулах салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос 1,468.0 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлэхээр тооцсон байна. Ингэснээр ҮБС-ийн орлого ирэх онд 2026 оны төсвийн тодотголын төсөлд тусгаснаас 1,564.8 тэрбум төгрөгөөр өсөхөөр байна.

Хүснэгт 11. ҮБС-ийн орлого, зарлага, тэрбум төгрөг

№	Үзүүлэлт	2024	2025	2026 тод.	2027*
	Орлого	1,341.9	2,156.9	3,415.4	4,980.2
1	ҮБС-ийн тухай хуулийн 11.1.1.а-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн	841.4	1,409.6	2,633.1	2,930.8

	хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь				
2	Мөн хуулийн 11.1.1.б-д заасан хөрөнгө оруулалтын орлогыг Ирээдүйн өв санд	-	144.3	253.4	347.1
3	Хуулийн 11.1.2-т заасан уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ногдол ашиг	495.7	507.1	372.9	1,468.0
3.1.	Үүнээс: “Оюу толгой” ХХК-ийн ногдол ашиг	-	-	-	1,000.0
4	Хуулийн 10.3-т заасан хөрөнгө оруулалтын орлогыг Хуримтлалын санд	4.9	95.8	156.0	234.3
	Зарлага	-	0.00	0.00	1,000.0
1	Хуримтлалын сангийн зарлага	-	0.00	0.00	1,000.0

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл, тооцооллын хавсралт

8.3. Хөрөнгийн удирдлагыг зөв хэрэгжүүлэх арга замыг сонгохдоо үндэсний эрх ашгийг бодолцох шаардлагатай. Засгийн газар дэлхийн хамгийн том хөрөнгө оруулалтын менежментийн компани болох БлэкРок компанитай төрийн өмчит компаниудын засаглал, баялгийн сангийн менежментийг сайжруулах чиглэлээр хамтарч ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг саяхан байгуулсан. “БлэкРок ФМА” нь олон улсын зах зээлд гаргасан манай Засгийн газрын бондын гол эзэмшигчдийн нэг тул бидний хувьд аль хэдийн стратегийн чухал түнш болсон бөгөөд энэхүү аварга компанитай хамтран ажилласнаар санхүүгийн шийдвэрийг улс төрчдийн лоббиноос ангид, мэргэжлийн түвшинд гаргах, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл сэргэх, баялгийн сангийн хөрөнгийг урт хугацаанд тогтвортой арвижуулж боломж бүрдэх ач холбогдолтой. Гэхдээ нөгөө талаас баялгийн сангийн хөрөнгө оруулалтын стратегийг гадны корпорацид хэт их даатгавал Монгол Улс өөрийн баялагтаа эзэн байж, дотоодын хөгжлийн том төслүүдээ санхүүжүүлэх шийдвэр гаргах эрх мэдэл хязгаарлагдаж магадгүйг анхаарах хэрэгтэй болно.

8.4. Оюутолгой төслийн ногдол ашгийг томоохон хөрөнгө оруулалтад чиглүүлэх нь зөв алхам юм. Засгийн газраас дэвшүүлсэн “Чөлөөль” санаачилгын хүрээнд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбар дахь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшилд ногдох ногдол ашгийн орлогоос Үндэсний баялгийн санд хуваарилаад үлдэх хэсгийг улсын төсөвт ногдол ашгийн орлого хэлбэрээр төвлөрүүлэн Ган үйлдвэрлэлийн цогцолбор, Нүүрс-пиролизын үйлдвэр, Зэс боловсруулах үйлдвэрийн цогцолбор барих болон Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслүүдийг эрчимжүүлэхээс гадна Тавантолгойн 450 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц, Зөөвч-Овоо төслийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг эхлүүлэх болон гадаргын усыг хуримтлуулан ашиглах “Хэрлэн-Тооно” төсөл, “Хойд бүргэд” алтны үндсэн орд, Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах төслүүдийн үйл ажиллагааг эхлүүлэх, мөн Оюу толгой төслөөс 2027 онд төрийн эзэмшилд ногдох ашгийн орлогоос 3,000.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, эрчим хүчний суурь дэд бүтцийн тулгамдаж буй асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэх зорилтыг бидний зүгээс зөв зүйтэй алхам гэж үзэж байгааг тэмдэглэе.

8.5. Үндэсний баялгийн сангийн хөрөнгийн удирдлагыг сайжруулах нь бодлогын дараагийн томоохон алхам юм. Цаашид Үндэсний баялгийн сангийн хөрөнгийг арвижуулах, менежментийг сайжруулахад шилдэг туршлага, менежменттэй олон улсын

сангууд (тухайлбал Норвегийн Тэтгэврийн сан, Сингапурын Temasek гэх мэт)-ын загвараар тодорхой практик алхмуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Тухайлбал, уул уурхайн орлогыг шууд зарцуулах биш, Ирээдүйн өв сан болон Тогтворжуулалтын сангийн хөрөнгийг дэлхийн томоохон биржүүдээр арилжаалагддаг сангуудад байршуулж эхэлбэл хамгийн бага зардлаар, хамгийн найдвартай урт хугацааны өгөөж олох боломжтой. Мөн тухайн сангуудын хөрөнгийг үндэсний эдийн засаг, хувийн хэвшлийг дэмжих бодлого хэрэгжүүлэхэд зарцуулах нь эдийн засгийн өсөлтөд эергээр нөлөөлнө. Улмаар сангийн эзэмшиж буй хувьцаа, бонд, тэдгээрийн өгөөж, алдагдлыг улирал бүр олон нийтэд тодорхой мэдээлдэг байх нь ил тод байдлыг хангах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхэд чухал алхам болно.

9. УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГОД НИЙЦСЭН ЭСЭХ

9.1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг хэлэлцэн батлах шаардлагатай байна. УИХ 2020 оны 5 дугаар сард хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай (ХБТТУТ) хуулийг батлан гаргасан. Мөн үүний хамт Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын Хараа 2050”-ыг батлан гаргасан билээ. ХБТТУТ хууль болон “Алсын Хараа 2050”-ыг батлан гаргах явцдаа УИХ-аас тогтоол батлан гаргаж өмнөх жилүүдэд УИХ-аас батлагдсан салбарын хөгжлийн хөтөлбөрүүд, төрөөс баримтлах бодлогын олон баримт бичгийг хүчингүй болгосон. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д *“Дунд хугацааны буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих хөгжлийн бодлогын баримт бичиг нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх дараах хөгжлийн зорилтот хөтөлбөр байна:*

- 6.5.1.хүний хөгжлийн зорилтот хөтөлбөр;*
- 6.5.2.нийгмийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;*
- 6.5.3.эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;*
- 6.5.4.байгаль орчны зорилтот хөтөлбөр;*
- 6.5.5.засаглалын зорилтот хөтөлбөр;*
- 6.5.6.бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр;*
- 6.5.7.үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр.*
- 6.5.8.шинжлэх ухаан, технологийн зорилтот хөтөлбөр.*
- 6.5.9.хүний эрх, эрх чөлөөг хангах зорилтот хөтөлбөр;*
- 6.5.10.эрх зүйн шинэтгэлийн зорилтот хөтөлбөр”* байна гэж заасан.

Хэдийгээр 2022 онд Засгийн газраас хуульд заасан хөгжлийн хөтөлбөрүүдийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барьсан хэдий ч эдгээр хөтөлбөрийг УИХ-ын чуулганаар өнөөг хүртэл хэлэлцээгүй, хэлэлцэн батлаагүй байна. Үндсэндээ 2020 оноос хойш өнөөг хүртэл Монгол Улс урт хугацааны бодлого, таван жилийн хөгжлийн төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гэсэн хөгжлийн бодлогын 3 баримт бичгийг мөрдөж ирлээ. Гэвч улс орны хөгжилд, үүний дотор тодорхой салбарыг урт хугацаанд зөв чиг баримжаатай хөгжүүлэхийн тулд дунд хугацааны хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлсон баримт бичиг зайлшгүй шаардлагатай байдаг. Жишээлбэл, УИХ-аас 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”, мөн 2015 оны УИХ-ын 63 дугаар тогтоолоор батлан гаргасан “Төрөөс эрчим хүчний талаар

баримтлах бодлого”, УИХ-ын 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого” зэрэг бодлогын баримт бичгүүд нь эдгээр салбарын дунд хугацааны хөгжлийн зорилтыг оновчтой тодорхойлсон, салбарын хөгжлийн чиг баримжааг зөв зүйтэй тодорхойлсон баримт бичгүүд байсан.

Гэтэл энэ мэт олон тооны бодлогын баримт бичгийг хүчингүй болгосон атлаа түүнийг орлох учиртай хөгжлийн хөтөлбөрүүдийг хэлэлцэн батлалгүй 6 жил өнгөрч байгаа нь олон салбарын хөгжлийн цаашдын ирээдүйг бүрхэг, олон салаа замтай, тухайн жилд салбарыг тэргүүлж байгаа сайд өөрт таалагдсан буюу өөрийн сонгосон аль нэг замыг сонгон зорилтоо тодорхойлох боломжийг олгож, урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтыг гажуудуулж болзошгүй байна. УИХ-аас хэлэлцэн баталж байгаа Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, төлөвлөгөө нь чухал боловч салбар тус бүрийн нарийн асуудлыг төдийлөн тусгах боломж байдаггүй, учир дутагдалтай байдаг.

9.2. “Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г хэлэлцэн батлах шаардлагатай байна. 2025 оны 1 дүгээр сард Монгол Улсын Засгийн газраас “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөг батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл, мастер төлөвлөгөөг УИХ-д өргөн барьсан боловч мөн хэлэлцээгүй хүлээгдэж байна. Бодлогын бүрхэг тодорхойгүй байдлын уршгаар өнгөрсөн жилүүдэд түлш эрчим хүч, дэд бүтцийн салбарт хийгдэх ёстой байсан бодлогын шийдлүүд, алсыг харсан хөрөнгө оруулалт ихээхэн дутагдаж иржээ.

9.3. Төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалт дотор Монгол Улсын 2026-2030 оны улсын хөгжлийн 5 жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 3.2 их наяд төгрөгийн санхүүжилтгүй 436 төсөл, арга хэмжээ байгаа бөгөөд энэ нь төсвийн нийт хөрөнгө оруулалтын тайлант онд санхүүжих дүнгийн 55.4 хувийг эзэлж байна. Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1 дүгээр зүйлийн дагуу Сангийн яам нь жилийн төсвийн төслийг боловсруулахдаа улсын төсвийн төлөвлөлтийг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулах талаар анхаарах нь зүйтэй. Монгол Улсын 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 815 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж санхүүжилтэд 5,773.8 тэрбум төгрөг тусгасан байна.

Хүснэгт 12. Төсвийн хөрөнгө оруулалт дотор улсын хөгжлийн 5 жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт, салбараар, тэрбум төгрөгөөр

Салбарын ангилал	Төслийн тоо	2027 онд санхүүжүүлэх дүн	Нэгдсэн төсөвт эзлэх хувь
Төрийн төв байгууллагууд	66	531.7	1.2
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	86	627.8	1.4
Хууль сахиулах, батлан хамгаалах	38	98.9	0.2
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	21	60.0	0.1
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй	17	95.1	0.2
Дэд бүтэц	192	1,739.2	4.0
Эрүүл мэнд	16	48.0	0.1
Нийт	436	3,200.8	7.3

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёрдугаар хавсралт

Үүнээс Монгол Улсын 2026-2030 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 379 төсөлд 2,573.1 тэрбум төгрөгийн санхүүжилт, харин тус төлөвлөгөөнд тусгагдаагүй 436 төсөлд 3,200.8 тэрбум төгрөгийн санхүүжилт зарцуулахаар төлөвлөжээ. Таван жилийн хөгжлийн

төлөвлөгөөнд тусгагдаагүй 436 төслийн тайлант оны санхүүжилт нь 2027 оны нэгдсэн төсвийн нийт зарлагын 7.3 хувь, нэгдсэн төсвийн нийт хөрөнгө оруулалтын тайлант оны санхүүжилтийн 55.4 хувийг тус тус эзэлж байна.

9.4. Төсвийн хөрөнгө оруулалт Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй харьцангуй өндөр нийцэлтэй байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт 815 төсөл, арга хэмжээний 802 буюу 98.4% (санхүүжилтийн дүнгээр 96.8%, 5,588.1 тэрбум төгрөг) нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (ЗГҮАХ)-ийн тодорхой заалттай нийцэж байна. Үлдэх 13 төсөл (185.7 тэрбум төгрөг, 3.2%) нь ЗГҮАХ-тэй чиглэлийн хувьд нийцтэй байна. Нийт хөрөнгө оруулалтын дийлэнх хэсэг буюу 51.1% (2,950.3 тэрбум төгрөг) нь ЗГҮАХ-ийн эдийн засгийн бодлого, 30.5% (1,762.9 тэрбум төгрөг) нь хүний хөгжлийн бодлогод тус тус тусгагдсан байна.

Хүснэгт 13. Улсын Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртэй нийцсэн байдал

Бүлэг	Санхүүжилт, тэрбум төг.	Хувь	Төслийн тоо
Бүсчилсэн хөгжлийн бодлого	570.6	9.9	12
Хүний хөгжлийн бодлого	1,762.9	30.5	411
Эдийн засгийн бодлого	2,950.3	51.1	283
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	490.0	8.5	109
Нийт дүн	5,773.8	100	815

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёрдугаар хавсралт

10. УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ЭСЭХ

10.1. “Монгол Улсын 2027 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтүүдтэй нийцүүлэх шаардлагатай байна. Монгол Улсын 2027 оны төсвийн төслийг боловсруулахдаа УИХ-аас баталсан Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн хөгжлийн төлөвлөгөө, 2027 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг үндэслэн боловсруулжээ. 2027 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан салбарын зорилтууд ирэх оны төсвийн төсөлд ямар нэг хэмжээгээр тусгагдсан байна.

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 2025 оны 113 дугаар тогтоолын 6 дахь заалтад “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн үр дүнгийн хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд заасан зорилтыг хангахуйц, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн зарчим, шалгуурыг хангасан төсөл, арга хэмжээг улсын эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэмбэлж, 2027, 2028, 2029, 2030 оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байх” гэсэн заалтын дагуу зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн төсөлд тусгажээ.

Салбарын яамдын хувьд ирэх 2027 онд хэрэгжүүлэх зорилт арга хэмжээ, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлон тусгасан байна. Гэхдээ жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан шалгуур үзүүлэлтүүд өөр, харин 2027 оны төсвийн төсөлд тусгагдсан тухайн салбарын хүрэх түвшний шалгуур үзүүлэлтүүд өөр байх, зарим ижил

зорилт бүхий хүрэх түвшинг өөр өөрөөр тооцож тусгасан зэрэг алдаа, дутагдалтай зүйлс цөөнгүй тусгагджээ.

Иймээс төсвийн төслийн хэлэлцүүлгийн явцад Засгийн газар, салбарын яамд 2027 оны эцэст хүрэх түвшний шалгуур үзүүлэлтүүдийг дахин нягтлан үзэж алдаатай, зөрүүтэй тусгагдсан хүрэх түвшин, тоон үзүүлэлтүүдийг засварлах, УИХ-ын 2026 оны 29 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2027 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтүүдтэй нийцүүлэх шаардлагатай байна.

10.2. Төсвийн хөрөнгө оруулалтад Монгол Улсын 2027 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд суугдаагүй 1.7 их наяд төгрөгийн дүнтэй 309 төсөл, арга хэмжээ байгаа нь тайлант оны төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн 29.4 хувийг эзэлж байна. Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8 дахь заалтын дагуу жилийн төсвийн төсөл нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх ёстой. Тиймээс жилийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад багтсан төсөл, арга хэмжээ нь тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байх шаардлагыг мөрдөж явах нь зүйтэй. Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд улсын төсвөөр санхүүжүүлэх нийт 217 төсөл, арга хэмжээнд 2,639.6 тэрбум төгрөг, үүнээс хөрөнгө оруулалтын төсөлд 1,780.0 тэрбум төгрөгийг зарцуулахаар баталсан.

Хүснэгт 14. Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө болон Төсвийн төсөлд тусгагдсан улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын дүн, тоо (тэрбум төгрөг)

Салбарын ангилал	Хөгжлийн төлөвлөгөөнд туссан				2027 онд улсын төсвөөр санхүүжих хөрөнгө оруулалт	
	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс: Хөрөнгө оруулалтын төсөл			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэд бүтэц	27	801.0	22	766.2	226	1,758.5
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	41	835.0	15	444.7	346	1,125.3
Эрүүл мэнд	17	334.2	4	257.6	45	163.8
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	10	25.2	4	19.4	-	-
Төрийн төв байгууллагууд	46	122.3	15	98.9	70	415.4
Хууль сахиулах, батлан хамгаалах	21	133.6	13	112.6	52	235.4
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй	47	332.2	12	80.8	24	75.5
Хүнд үйлдвэр	8	55.7	1	-	-	-
Нийт дүн	217	2,639.3	86	1,780.0	763	3,773.8

Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёрдугаар хавсралт, Монгол Улсын 2027 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө

Харин 2027 оны төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын 763 төсөлд 3,773.8 тэрбум төгрөгийг төлөвлөсөн байна. Гэтэл Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтад ороогүй 2027 оны төсвийн төсөлд тусгагдсан 1,749.2 тэрбум төгрөгийн 309 төсөл байна.

11. ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ШАЛГУУРЫГ ХАНГАСАН ЭСЭХ

А. Одоо хүчин төгөлдөр мөрдөж буй төсвийн тусгай шаардлагыг хангаж буй эсэх

11.1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх. Өргөн мэдүүлсэн төсөлд 2027 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 10,249.9 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 125.4 ам.доллар байхаар төсөөлсөн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.3-т заасан тодорхойлолтын дагуу тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон гэж үзэх үндэслэл болж байна.


11.2. Нэгдсэн төсвийн суурь тэнцэл ашигтай байх. Хуулийн төсөлд энэхүү шаардлагыг хангасан эсэх талаарх мэдээлэл, тооцоолол тусгагдаагүй тул энэ шаардлагыг хангасан талаарх дүгнэлт өгөх боломжгүй байна.

11.3. Засгийн газрын өрийн нийт хэмжээ. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2027-2029 онуудад хуульд заасан хязгаарт буюу 50 хувь, 50 хувь, 45 хувь байхаар тооцоолжээ.

11.4. Урсгал зардал. Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн урсгал зардлыг 33,583.2 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд уг дүн нь тухайн жилийн ДНБ-ий 29.1 хувьтай тэнцэж байна. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан нэгдсэн төсвийн урсгал зарлага тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагаас 0.9 нэгж хувиар доогуур байна.

Б. Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд тусгагдсан төсвийн тусгай шаардлагыг хангаж буй эсэх

Зураг 22. Эрдэс баялгийн бус ДНБ-ний нэрлэсэн өсөлтийн таамаглал



11.5. Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ. Нэгдсэн төсвийн нийт зарлага 2027 онд 28.2 хувиар өсөхөөр төсөөлсөн нь 2026 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Засгийн газраас өргөн барьсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт нь тухайн жилийн эрдэс

баялгийн бус ДНБ-ий өсөлт болон өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх” шаардлагыг хангахгүй байна⁹.

11.6. Тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-т “2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэж заасан. Өргөн мэдүүлсэн төсөлд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2027-2029 онуудад ДНБ-ий -2.0, -1.5, -1.0 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангасан байна.

12. ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

Төрийн оролцоог бууруулах, мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь нэмэгдэж төрийн оролцоо өсөж байгаа нь төрийн оролцоог нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн орон зайг хязгаарлах нөхцөл болж байгааг анхаарч цаашид төрийн оролцоог бууруулах, хувийн хэвшлийг дэмжих бодлогыг тууштай хэрэгжүүлэх.

Шинээр хэрэгжүүлэх томоохон бодлогын өөрчлөлт, түүнтэй холбоотой хуулийг батлан хэрэгжүүлэхдээ богино, дунд хугацаанд төсөвт үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг тооцдог болох. 2027 оны төсвийн тэлэлт нь татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчдын цалин хөлсний нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой байгаа бөгөөд үүнээс шалтгаалж урсгал зардал их хэмжээгээр өсөх нөхцөл бүрдэж байна. Энэ нь төсвийн орлого, зарлагын тэнцвэр, бодлогын орон зайд сөргөөр нөлөөлж байгаа тул цаашид төсөвт томоохон нөлөөлөл үзүүлэх бодлогын нөлөөлөл, үр дагаврыг нарийвчлан тооцож байх.

Төсвийн орлогыг төрийн өмчит компанийн ногдол ашиг, Оюутолгой төслийн ногдол ашгийг татан төвлөрүүлэх замаар нэмэгдүүлж байгаа тул төсвийн орлогын бодлогыг өөрчилж байгаатай холбоотойгоор эерэг, сөрөг нөлөөллийг тооцох. Зөвлөлийн зүгээс төрийн өмчийн компанийн ногдол ашгийг төсвийн орлогод татан төвлөрүүлж байгааг эерэг хэмээн үзэж байгаа ч энэ орлогыг юунд зориулан зарцуулахаас хамаарч эрсдэл бий болох магадлалтай хэмээн үзэж байна.

Төрийн албан хаагчдын цалин хөлсний бодлогыг эдийн засгийн нөхцөл байдал, хувийн хэвшилд үзүүлэх нөлөөлөлд суурилан хэрэгжүүлэх. Цалин хөлсний зардал ихээхэн нэмэгдэж байгаа нь төсвийн зарлагын өсөлтийн гол хэсэг болж байгаа төдийгүй төсвийн бодлогын орон зайг шахаж байна. Түүнчлэн төрийн албан хаагчдын цалин хөлсийг орлого дагуулан өсгөх нь эдийн засгийн нөхцөл байдалд нийцтэй бус байх, хувийн хэвшилд дарамт болох нөхцөлийг бүрдүүлэх тул цаашид эдийн засгийн нөхцөл байдал, бүтээмжтэй уялдуулан тодорхойлох.

Засгийн газрын нийт өр болон өрийн үйлчилгээний зардлын хэтийн төлөв, эрсдэлийг тооцож, төсвийн бодлогын хэрэгжилтэд анхаарах. Засгийн газрын нийт өр болон өрийн үйлчилгээний динамикийг дотоодын болон олон улсын босго утгуудтай харьцуулж үзэхэд 2026-2027 онд холбогдох хязгаарын дотор байх хүлээлттэй байгаа боловч улсын төсвийн

⁹ Төсвийн хүрээг дагуулан өргөн мэдүүлсэн хуульд энэ заалтыг харгалзахгүй байх хуулийн өөрчлөлтийг Засгийн газраас санал болгосон.

зарлагад Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрийн эзлэх дүн нэмэгдэж, тодорхой дарамтыг учруулахаар байгааг анхаарч холбогдох арга хэмжээг авах.

УИХ-аас баталсан тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах хэрэгтэй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой асуудлаар УИХ-аас удаа дараа тогтоол, шийдвэр гарган Засгийн газарт үүрэг даалгавар өгч ирсэн. Эдгээр тогтоолын заалтын хэрэгжилтийг хангах талаар ажиллах, биелэлтийг Монгол Улсын Засгийн газраас тодруулга, тайлбар, тайлан хэлбэрээр авч занших нь төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд эерэг нөлөөтэй.

Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг батлах, төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой Улсын Их Хурлаас баталсан тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах нь төсвийн төлөвлөлт, үр дүнтэй хэрэгжилтийн гол үндэс болохыг анхаарах. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийг хэлэлцэн батлах шаардлагатай. Мөн УИХ-аас төсвийн тухай хууль, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтыг сайжруулахтай холбогдон гаргасан удаа дараагийн тогтоолуудын хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах асуудалд анхаарах.

Төсвийн тусгай шаардлагыг сайжруулах, тогтвортой байдлыг хадгалах, тууштай мөрдөхөд анхаарах. Төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх, үйлчлэлийг хойшлуулах хандлага уг хууль батлагдсанаас хойш үргэлжилсээр ирсэн нь төсвийн тогтвортой байдлын тухай хуульд олон удаа өөрчлөлт оруулах гол шалтгаан болсон. Үүний үр дүнд төсвийн тусгай шаардлагууд хэрэгжих нөхцөл алдагдаж байснаас төсвийн бодлогын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж ирснийг анхаарах.

Хавсралт 1. Төсвийн урсгал зардлын бүрэлдэхүүний инфляцад үзүүлэх нөлөө


Үнэлгээний тайлбар, арга зүй ба үр дүнгийн эмхэтгэл

ТТБЗ-ийн Судалгааны нэгжээс хийсэн судалгааны зарим үр дүнгээс

Зардал тус бүрээр авч үзэхэд:


Зураг 23. Урсгал зардал болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн шоконд үзүүлэх инфляцын хариу үйлдэл

Урсгал зардлын шоконд үзүүлэх инфляцын хариу үйлдэл




95 % Bootstrap CI, 100 runs

Татаас ба урсгал шилжүүлгийн зардлын шоконд үзүүлэх инфляцын хариу үйлдэл




95 % Bootstrap CI, 100 runs

Бараа үйлчилгээний зардлын шоконд үзүүлэх инфляцын хариу үйлдэл



95 % Bootstrap CI, 100 runs

Цалин, хөлсний зардлын шоконд үзүүлэх инфляцын хариу үйлдэл



95 % Bootstrap CI, 100 runs

- Урсгал зардлын өсөлтийн нэг нэгж стандарт хазайлтын шоконд үзүүлэх инфляцын хариу үйлдэл 3 үеийн дараагаар хамгийн өндөр утга авч байгаа бөгөөд сарын инфляцын өсөлтийн хурд 0.06-0.07 нэгжээр нэмэгдэхээр байна. Өөрөөр хэлбэл, урсгал зардлын өсөлт нэг нэгж стандарт хазайлтаар буюу 1.75 пунктээр өсөхөд сарын инфляц 0.06-0.07 пунктээр өсдөг байна. Урсгал зардлын өсөлт 10 пунктээр өсөхөд инфляц 12 сарын хуримтлагдсан нийт нөлөөгөөр 0.4 пунктээр нэмэгдэхээр байна.
- Татаас ба урсгал шилжүүлгийн зардлын өсөлт нэг нэгж стандарт хазайлтаар буюу 2.2 пунктээр өсөхөд 3 үеийн дараагаар сарын инфляц 0.07 пунктээр нэмэгдэхээр байна. Урсгал шилжүүлгийн зардлын шок бусад хувьсагчтай харьцуулахад статистик ач холбогдол хамгийн сул байна.
- Цалингийн зардлын өсөлтийн шоконд үзүүлэх инфляцын хариу үйлдэл бусад зардлын өсөлтийн шокуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Тодруулбал, цалингийн зардлын өсөлт нэг нэгж стандарт хазайлтаар нэмэгдэх буюу 0.8 пунктээр өсөх шоконд инфляц 3 сарын дараагаар 0.13 пунктээр өсөх хариу үйлдэл үзүүлж

байна. Цалингийн зардлын өсөлт 10 пунктээр нэмэгдэхэд инфляц 12 сарын хуримтлагдсан нийт нөлөөгөөр 2.1 пунктээр нэмэгдэхээр байна. 2025 онд цалин хөлсний зардал 15.9 хувиар нэмэгдсэн, 2026 оны тодотголоор 24 хувиар нэмэгдэхээр байгаа буюу 2025 оны цалингийн зардлын өсөлтөөс даруй 8 хувь өндөр байгаа нь инфляцад ойролцоогоор 1.7 хувийн өсөлтийг бий болгохоор байна.

- Бараа, үйлчилгээний зардал цалингийн зардалтай ижил түвшинд буюу нэг нэгж стандарт хазайлтын шоконд 3 үеийн дараагаар сарын инфляц [0.13:0.15] пунктээр өсөх төлөвтэй байна.

Монгол Улсад хийгдсэн энэ төрлийн судалгааны үр дүнг багцлан авч үзвэл төрийн албан хаагчийн цалин болон цалингийн зардал 10 хувь нэмэгдэхэд инфляц 4 орчим хувиар өсдөг гэсэн нийтлэг үр дүнд хүрсэн байна.

Үүнээс гадна Судалгааны нэгж Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020-2027 оны нэрлэсэн болон бодит нийт зарлага, урсгал зардал, хөрөнгийн зардлын харьцуулсан шинжилгээ хийж, зардлын төрөл бүрээр өсөлтийг гарган харьцуулж үзсэн. Эндээс бараг бүх зардлын бодит өсөлт 100.4-308.4 хувь байхад Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж л 2026 оны тодотголоор 98.2, 2027 онд 99.2 хувьтай буюу буурч байгаа нь анхаарал татаж байна. Учир нь иргэдийн орлогыг хамгаална гэсэн зорилго дэвшүүлсэн байтал нийгмийн халамжийн зардал нь бодитоор өсөөгүй, бүр буурч байх юм.

Хавсралт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой асуудлаар УИХ-аас гаргасан тогтоолууд

“Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2021 оны 88 дугаар тогтоолын заалтаас:

4/улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалж, үнийн өөрчлөлтийн индексийг батлах;

5/улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт магадлал хийх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, холбогдох саналаа **2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө УИХ-д танилцуулах;**

“Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 72 дугаар тогтоолын заалтаас:

3/Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;

“Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2023 оны 93 дугаар тогтоолын заалтаас:

10/төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, ашиглалтад хүлээн авах, өмчид хүлээн авах үйл ажиллагаанд ногоон байгууламжийн стандарт болон тусгай хэрэгцээт иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандартыг чанд мөрдөж хэрэгжүүлэх, зохион байгуулах;

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2026 оны 31 дүгээр тогтоолын заалтаас:

1.Улс, орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалт /цаашид "төсвийн хөрөнгө оруулалт" гэх/-аар болон Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Учрал/-т даалгасугай:

1/төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж эхэлсэн боловч бүрэн дуусаагүй зогссон төсөл, арга хэмжээний ашиглалтад ороогүй шалтгаан, төсөвт үзүүлж байгаа үр дагавар, нөлөөллийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр судалж, холбогдох тайлан болон цаашид төсвийн хөрөнгө оруулалтаар үргэлжлүүлэх, эсхүл өмчлөлийн өөр хэлбэрт шилжүүлэх зэрэг асуудлаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналаа **2026 оны 09 дүгээр сарын 15-ны дотор УИХ-д танилцуулах;**


Хавсралт 3. Цалин, тэтгэврийн зардлын дунд хугацааны төлөв

Урсгал шилжүүлэг, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн тодорхой хэсэг нь дараагийн жилүүдэд мөн үргэлжлэн гарах зардлын шинжтэй байдаг. Ирэх оны зарлагын өсөлтийн дийлэнх хэсэг нь нэг удаагийн бус, дараагийн жилүүдэд давтан гарах шинжтэй байгаа тул 2027 оны цалин хөлс, өндөр настны тэтгэврийн зардлын өсөлтийг зөвхөн тухайн жилийн төсвийн хүрээнд бус, уг өсөлтөөс 2028–2029 онд шинээр бий болох төсвийн суурь дарамтыг тооцоолж, дараах хэсэгт тусгасан болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зардлын цалин хөлсний зардал (үндсэн цалин, нэмэгдэл цалин) болон өндөр настны тэтгэврийн зардлын 2028-2029 оны өсөлтийн хэмжээг тус бүр 3 хувилбараар тооцов. Монгол Улсын 2027 оны төсвийн үзэл баримтлалд төрийн албан хаагчдын цалин, ахмад настны тэтгэврийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ гэж заасны дагуу цалин хөлс болон өндөр настны тэтгэврийн зардлыг нэмэгдүүлж, мөнгөн дүнгээр болон Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зардалд эзлэх хувиар харуулав.

Цалин хөлсний зардлын дунд хугацааны төсөөллийг хийхдээ цалин хөлсний өсөлтийг тодорхойлох 3 хувилбараар тооцоолол хийв. Үүнд:

Зураг 24. Үндсэн ба нэмэгдэл цалингийн зардлын хэмжээ, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Монгол Улсын 2027 оны төсвийн төсөл, 2027-2029 оны ТХМ-д үндэслэн хийсэн ТТБЗ-ийн тооцоолол

1. Инфляцад суурилсан хувилбар: Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан хэрэглээний үнийн өсөлтийн төсөөллийг ашиглан үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний зардлын өсөлтийг тооцов. Тодруулбал, инфляц 2028 онд 7 хувь, 2029 онд 6 хувь байхаар төсөөлсөн байна. Монгол Улсын 2027 оны төсвийн төсөлд тусгагдсан үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний зардлын дүнг тухайн жилийн хэрэглээний үнийн өсөлтийн хувь хэмжээгээр нэмэгдүүлэн тооцсон.

2. Инфляц болон эдийн засгийн бодит өсөлтөд суурилсан хувилбар: Цалин хөлсний зардлын өсөлтийг инфляц болон эдийн засгийн бодит өсөлтийн нийлбэрээр тодорхойлов. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан хэрэглээний үнийн өсөлт болон ДНБ-ий бодит өсөлтийн төсөөллийг ашиглан 2028 онд 7 хувь + 6 хувь = 13 хувь, 2029 онд 6 хувь + 6.3 = 12.3 хувийн өсөлтөөр тус тус цалин хөлсний зардлыг нэмэгдүүлэн тооцсон.

3. Сүүлийн 10 жилийн дундаж өсөлтөд суурилсан хувилбар: Цалин хөлсний зардлын сүүлийн 10 жилийн дундаж өсөлтийн хувь хэмжээг тооцож, уг дундаж өсөлтийг 2028, 2029 оны үндсэн болон нэмэгдэл цалин хөлсний зардлын төсөөлөлд ашиглав.

Зураг 25. Нийт төсвийн зардалд үндсэн ба нэмэгдэл цалингийн зардлын эзлэх хувь



Өндөр настны тэтгэврийн зардлын дунд хугацааны төсөөллийг хийхдээ өсөлтийг тодорхойлох 2 хувилбараар тооцоолол хийв. Үүнд:


1. Инфляцад суурилсан хувилбар: Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан хэрэглээний үнийн өсөлтийн төсөөллийг ашиглан өндөр настны тэтгэврийн зардлыг тооцов. Тодруулбал, 2028 онд **7 хувь**, 2029 онд **6 хувийн** инфляцтай байхаар тооцсон бөгөөд 2027 оны төсвийн төсөлд тусгагдсан өндөр настны тэтгэврийн зардлын дүнг тухайн жилийн хэрэглээний үнийн өсөлтийн хувь хэмжээгээр нэмэгдүүлэн тооцсон. Үр дүнгээс харахад, 2028 онд өндөр настны тэтгэврийн зардлын хэмжээ 6,219.4 тэрбум төгрөг, 2029 онд 6,592.5 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Энэ нь Монгол Улсын 2028 оны нэгдсэн төсвийн нийт зардлын 14.7 хувь, 2029 оны нэгдсэн төсвийн нийт зардлын 14.9 хувийг бүрдүүлэх юм.

2. Инфляц болон эдийн засгийн бодит өсөлтөд суурилсан хувилбар: Өндөр настны тэтгэврийн зардлын өсөлтийг инфляц болон эдийн засгийн бодит өсөлтийн нийлбэрээр тодорхойлов. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан хэрэглээний үнийн өсөлт болон ДНБ-ий бодит өсөлтийн төсөөллийг ашиглан 2028 онд 7 хувь + 6 хувь, 2029 онд 6 хувь + 6.3 хувийн өсөлтөөр тус тус өндөр настны тэтгэврийн зардлыг нэмэгдүүлэн тооцсон. Үр дүнгээс харахад, 2028 онд өндөр настны тэтгэврийн зардлын хэмжээ 6,568.1 тэрбум төгрөг, 2029 онд 7,376.0 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Энэ нь Монгол Улсын 2028 оны нэгдсэн төсвийн нийт зардлын 15.5 хувь, 2029 оны нэгдсэн төсвийн нийт зардлын 16.7 хувийг бүрдүүлэх юм.

Зураг 26. Өндөр настны тэтгэврийн хэмжээ



Зураг 27. Төсвийн нийт зардалд өндөр настны тэтгэврийн зардлын эзлэх хувь



ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ